

See discussions, stats, and author profiles for this publication at: <https://www.researchgate.net/publication/352872612>

Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс (Introduction to Human Geography)

Book · June 2021

CITATIONS

0

READS

4,944

7 authors, including:



Batchuluun Yembuu

Mongolian National University Of Education

118 PUBLICATIONS 214 CITATIONS

SEE PROFILE



Tsogbadral Khurelbaatar

MSUE

12 PUBLICATIONS 2 CITATIONS

SEE PROFILE



Sandag Khadbaatar

Mongolian National University of Education

78 PUBLICATIONS 53 CITATIONS

SEE PROFILE



Tsedev Bat-Erdene

Mongolian National University Of Education

23 PUBLICATIONS 14 CITATIONS

SEE PROFILE



НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАРЗҮЙН ҮНДЭС



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН ГАЗАРЗҮЙН
БОЛОВСРОЛЫН НИЙГЭМЛЭГ

НИЙГЭМ–ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАРЗҮЙН ҮНДЭС

Анхны хэвлэл

Ерөнхий редактор: Е.Батчулуун
Х.Цогбадрал

Улаанбаатар

ННА 26.8
ДАА 900
Н-588

МУБИС–ийн Математик, байгалийн ухааны сургуулийн Эрдмийн зөвлөлөөр газарзүйн багш боловсролын үндсэн сурах бичгээр батлав.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Газарзүйн тэнхимийн 70 жилийн ойд зориулав.

НИЙГЭМ–ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАРЗҮЙН ҮНДЭС

Хянан тохиолдуулсан: Е.Батчулуун, Х.Цогбадрал

Техник редактор: С.Хадбаатар

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Бүжидмаа

Зураач: Г. Амарсанаа

Цаасны хэмжээ: 172 x 245 1/10

Хэвлэлийн хуудас: 35,0

Хуудасны тоо: 420

Зохиогчийн эрх ©2021, Е.Батчулуун, Х.Цогбадрал

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан. Уг номын бүтэц, загварыг ашиглах, хэсэгчлэн болон бүтнээр нь хуулах, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр цахим хэлбэрт оруулах, дахин хэвлэхийг хориглоно.

“Мөнхийн үсэг” ХХК–д эхийг бэлтгэж “Адмон” ХХК–д хэвлэв. Улаанбаатар хот

ISBN:978-9919-24-612-9

Эшлэл авах: Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). *Нийгэм–эдийн засгийн газарзүйн үндэс*. Улаанбаатар, Монгол: Адмон принтинг. 420 х.

Citation: Yembuu, B & Tsogbadral, Kh. (Eds). (2021). *Introduction to Human Geography*. Ulaanbaatar, Admon printing. 420 pages.



MONGOLIAN NATIONAL UNIVERSITY
OF EDUCATION



MONGOLIAN ASSOCIATION
FOR GEOGRAPHIC EDUCATION

INTRODUCTION TO HUMAN GEOGRAPHY

First edition

Edited by Batchuluun Yembuu
Tsogbadral Khurelbaatar

Ulaanbaatar



Зохиогчдын баг

Ембүүгийн Батчулуун

Доктор (PhD), профессор



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Дэлхий судлал, Физик газарзүйн тайлбар толь, Газарзүйн боловсролын үндэс зэрэг ном, бүтээл туурвисан. ЕБС-ийн сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулах багийн ахлагч. Газарзүйн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн.

Хүрэлбаатарын Цогбадрал

Доктор (PhD)



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн эрхлэгч. Нийгэм-эдийн засгийн газарзүйн хичээл 20 гаруй жил заасан. Аялал, рекреацийн чиглэлээр судалгаа хийдэг, ЕБС-ийн сурах бичиг, багшийн ном зохиогчдын багийн гишүүн.

Пүрэвсүрэнгийн Энхжаргал

Магистр, ахлах багш



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Зурагзүйн хичээл 20 гаруй жил зааж, "Байрзүйн үндэстэй зурагзүй", "Зурагзүйн дадлага ажил" зэрэг ном туурвисан. ЕБС-ийн сурах бичиг зохиогчдын багийн гишүүн.

Цэдэвийн Бат-Эрдэнэ

Доктор (PhD), дэд профессор



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандах судлалын чиглэлээр ажилладаг. ЕБС-ийн сурах бичиг зохиогчдын багийн гишүүн.

Сандагийн Хадбаатар

Доктор (PhD), профессор



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Хөрс-ландшафтын чиглэлээр судалгаа хийж, Монгол-Оросын хамтарсан экспедицид ажилладаг. Байгал нуур, Экосистемийн атлас, ЕБС-ийн сурах бичиг зохиогчдын багийн гишүүн.

Цэдэвдоржийн Сэр-Од

Доктор (PhD)



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Физик газарзүйн хичээл зааж, Монгол Алтайн ландшафтын чиглэлээр судалгаа хийдэг. ЕБС-ийн сурах бичиг зохиогчдын багийн гишүүн.

Гэцэлийн Уранчимэг

Магистр, ахлах багш



МУБИС-ийн газарзүйн тэнхимийн багш. Газарзүйн дидактик, уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын чиглэлээр ажилладаг. ЕБС-ийн сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүн.

Бүлэг 1.	Нийгэм-эдийн засгийн газарзүйн ерөнхий ойлголт Х.Цогбадрал, П.Энхжаргал, Ц.Бат-Эрдэнэ	1
Бүлэг 2.	Хөгжлийн газарзүй Е.Батчулуун	29
Бүлэг 3.	Хүн амын газарзүй Е.Батчулуун	79
Бүлэг 4.	Соёлын газарзүй Е.Батчулуун, Х.Цогбадрал	125
Бүлэг 5.	Хотын газарзүй Ц.Бат-Эрдэнэ	153
Бүлэг 6.	Байгалийн нөөцийн газарзүй С.Хадбаатар	189
Бүлэг 7.	Үйлдвэрлэлийн газарзүй Е.Батчулуун, Г.Уранчимэг	215
Бүлэг 8.	Үйлдвэрлэлийн анхдагч салбарын газарзүй С.Хадбаатар	243
Бүлэг 9.	Үйлдвэрлэлийн хоёрдагч салбарын газарзүй Х.Цогбадрал	283
Бүлэг 10.	Үйлдвэрлэлийн гурав ба дөрөвдэгч салбарын газарзүй Ц.Сэр-Од	321
Бүлэг 11.	Байгаль-нийгмийн асуудлууд, тогтвортой хөгжил Е.Батчулуун, С.Хадбаатар	359

ЗУРГИЙН ГАРЧИГ*

1.1	НЭЗ-ийн газарзүй ба шинжлэх ухаан	3	2.17	Хүн амын дундаж наслалт ба ДНБ	73
1.2	НЭЗ-ийн газарзүйн судалгааны орон зайн хүрээ	4	2.18	Орлогын жигд бус хуваарилалт	74
1.3	НЭЗ-ийн газарзүйн судлагдахуун	4	2.19	Хөгжлийн үзүүлэлт ба тэгш бус байдал	74
1.4	НЭЗ-ийн газарзүйн судалгааны үндсэн аргууд	5	2.20	1,000 хүн амд ногдох өргөн хэрэглээний бараа	75
1.5	НЭЗ-ийн газарзүйн зургийн ангилал	8	2.21	Эрт нас баралтын ялгаа, улсуудаар (%)	76
1.6	Нийгэм-эдийн засгийн газарзүйн судалгааны төрлүүд	9	3.1	Хүн амын газарзүй	80
1.7	Газарзүйн зургийн анализын арга	12	3.2	Дэлхийн хүн амын өсөлтийн "J" муруй	81
1.8	Зурагзүйн дүрслэлийн аргууд	15	3.3	Хүн амын тоогоор тэргүүлэгч орнууд	81
1.9	Хоёр талт график (Канадын хүн ам)	17	3.4	Төрөлтийн коэффициент	83
1.10	Тойргон диаграмм (МО-ы импортын бүтэц)	17	3.5	Төрөлтийн түвшин	84
1.11	Гурвалжин диаграмм (Ажил эрхлэлт)	18	3.6	Төрөлтийн түвшин буурч буй байдал	85
1.12	Хамаарал ба тохиромжит шугам	18	3.7	Төрөлтийн түвшний өөрчлөлт ба хэтийн төлөв, бүс нутгаар	85
1.13	Гэрэл зургийн төрлүүд	21	3.8	Төрөх насны нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо, 1980 ба 2020 он	86
1.14	Гео-орон зайн технологийн хэрэглээ	22	3.9	Хүн амын ердийн өсөлтийн жилийн түвшин	87
1.15	Оптикийн тандан судалгааны зарчим	23	3.10	Хүн амын өсөлтийн хурдац	88
1.16	Зааны сүргийг хиймэл дагуулын тусламжтайгаар тоолж байгаа нь	24	3.11	Дэлхийн хүн амын өсөлт, 5 жил тутамд	88
1.17	А- растер ба вектор дүрслэл, Б-ГМС-ийн давхаргууд	25	3.12	Хүн амын өсөлт хурдацтай улсууд	89
1.18	Байршил тодорхойлох гурвалсан арга	26	3.13	Дэлхийн хүн амын төрөлт ба нас баралтын түвшин (1950-2100)	89
1.19	Хот төлөвлөлтөд шаардлагатай хиймэл дагуулын мэдээний нарийвчлал	26	3.14	Хүн амын тоо ба хэтийн төлөв	90
2.1	Хилийн шугамын төрөл	33	3.15	Африк тивийн хүн амын өсөлт	91
2.2	Улс орнуудын газарзүйн ялгаа	36	3.16	Дэлхийн болон бүс нутгуудын хүн амын насны бүлэг	92
2.3	Улс орнуудын төрийн тогтолцоо, 2010	37	3.17	Насны бүлгийн харьцааны өөрчлөлт	93
2.4	Дэлхийн улс төрийн зургийн өөрчлөлт	39	3.18	Хүн амын суваргын үндсэн хэлбэрүүд	94
2.5	Колончлогч улсуудын газар нутаг ба хүн амын харьцаа (1900 он)	40	3.19	Хүн амын нас хүйсийн бүтцийн өөрчлөлт	95
2.6	Африкийн улс төрийн зургийн өөрчлөлт	42	3.20	Хүн амын шилжилтийн загвар	96
2.7	Дэлхийн улс орнууд, а. 1914 он; б. 1959 он; в. 2020 он	45	3.21	Хүн амын дундаж наслалт, улсаар	98
2.8	Далайд гарцгүй улсууд	49	3.22	Дэлхийн хүн амын тархалт, суурьшил	99
2.9	Дэлхийн ДНБ-д эзлэх хувь	51	3.23	Дэлхийн хүн амын суурьшил, өргөргөөр	101
2.10	Орлогын ялгааны ангилал	53	3.24	Дэлхийн хүн амын суурьшил, тивээр	103
2.11	Зарим орны эдийн засгийн салбарын бүтэц	54	3.25	Нэг км ² талбайд ногдох хүн ам, бүс нутгаар	104
2.12	Хүний хөгжлийн индекс	60	3.26	Арифметик ба бодит нягтшил	105
2.13	Дэлхийн улсуудын хөгжлийн ангилал	65	3.27	Хүн амын шилжилтийн шалтгаан	107
2.14	"Хойд" ба "Өмнөд"-ийн орнууд	66	3.28	Хүн амын шилжилтийн төрлүүд	108
2.15	Нэг хотын хоёр төрх	68	3.29	Хүн амын шилжилтийн гол чиглэл	110
2.16	Хөгжлийн ялгаа: Хүн ам ба зарим үзүүлэлт	70	3.30	Цагаач хүн амын эзлэх хувь, зарим улсаар	111
			3.31	Булангийн орнууд руу чиглэсэн шилжилт	112

* Зарим гарчгийг товчлов.

- 11.18 Усны хямрал (улсуудаар) **376**
- 11.19 Усны хямралын өөрчлөлт **376**
- 11.20 Цэвэр усны хүртээмж **378**
- 11.21 Ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь **378**
- 11.22 Шистосомиаз өвчний газарзүйн тархалт **380**
- 11.23 Гэдэсний хижиг халдварт өвчний тархалт **380**
- 11.24 Хил дамнасан голын сав газар **381**
- 11.25 Хөрсний эвдрэлд зонхилж буй хүчин зүйлс **383**
- 11.26 Усалгаатай газар тариалангийн эзлэх хувь **383**
- 11.27 Хөрсний доройтол ихтэй нутгууд **384**
- 11.28 Хуурай бүс нутгийн газарзүйн тархалт **385**
- 11.29 Хуурай бүс нутгийн талбай ба хүн ам **385**
- 11.30 Хөрсний алдагдал тооцох **386**
- 11.31 Хөрсний элэгдлийн төрөл ба шалтгаан **386**
- 11.32 Хөрсний доройтлын шалтгаан, бүс нутгаар **387**
- 11.33 Ойн талбайн өөрчлөлт **388**
- 11.34 Шар буурцагны тариалан **388**
- 11.35 Ойгүйжиж буй талбай, улсаар **388**
- 11.36 Дэлхийн ойн талбай багассан байдал **389**
- 11.37 Байгалийн нөөц ашиглалтын үр дагавар **390**

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ*

- 2.1 Харьяалалтай нутаг дэвсгэр **31**
- 2.2 Улсуудын газар нутгийн ялгаа **34**
- 2.3 Хаант засаглалтай улсууд **36**
- 2.4 Холбооны улсууд **38**
- 2.5 Эдийн засгийн ялгаа, зарим улсаар **51**
- 2.6 Улсуудын ялгаа ДНБ-ээр **52**
- 2.7 Нэг хүнд ногдох ДНБ-ий хуваарилалт **53**
- 2.8 Нэг хүнд ногдох ҮНО-ын ялгаа **55**
- 2.9 Тэгш бус байдал, 2018 **56**
- 2.10 Амьдралын чанар ба ДНБ-ний хамаарал **57**
- 2.11 Хөгжлийн зарим үзүүлэлт (2018) **58**
- 2.12 ХХИ-ээр тэргүүлэгч орнууд **61**
- 2.13 Ядуурлын олон хэмжээст индекс **61**
- 2.14 ХХИ ба Аз жаргалын индексээр эзлэх байр **62**
- 2.15 Улс орнуудын хөгжлийн ангилал **64**
- 2.16 Хөгжингүй ба хөгжиж буй орнууд **70**
- 2.17 Спearманы хамаарлын коэффициент **71**
- 2.18 Хэрэглээ ба бохирдолд АНУ-ын эзлэх хувь **73**
- 3.1 Хүн амын тоо нэг тэрбумаар нэмэгдсэн хугацаа **81**
- 3.2 Хамгийн олон хүн амтай 10 улс **82**
- 3.3 Хүн амын тооны өөрчлөлт, бүс нутгаар **82**
- 3.4 Хүн ам 2 дахин өссөн хугацааны өөрчлөлт **87**
- 3.5 Хүн амын дундаж наслалтын ялгаа **98**
- 3.6 Хүн амын суурьшил, далай тэнгисээс алслагдсан байдлаар **100**
- 3.7 Хүн амын байршил, гадаргын өндөршлөөр **102**
- 3.8 Хүн ам нягт ба сийрэг суурьшилтай газрууд **104**
- 3.9 Хүн ам нягтшилын ялгаа, төрөл тус бүрээр **106**
- 3.10 Хот хөдөөгийн хоорондох шилжилт **107**
- 3.11 ДОХ ба дундаж наслалт **118**
- 3.12 65 ба дээш насныхны эзлэх хувь **119**
- 3.13 Японы хүн амын насны бүтэц ба төлөв **119**
- 4.1 Хэлтний тоогоор тэргүүлэх хэл **130**
- 4.2 Голлох шашны гарал үүсэл **142**
- 4.3 Шүтэгчдийн тоо ихтэй томоохон шашнууд **142**
- 4.4 Христийн шашин шүтэгчдийн тоо **145**
- 4.5 Томоохон үндэстнүүд **148**
- 4.6 Дэлхий голлох үндэстнүүд **150**
- 5.1 Суурьшлын ялгаа **155**
- 5.2 Хотыг ангилах шалгуурууд **159**
- 5.3 Дэлхийн хамгийн олон хүн амтай хотууд **167**
- 5.4 Хотжилтын түвшин, бүс нутгаар, 2019 **169**
- 5.5 Аж үйлдвэрийн хувьсгалаас хойших хотжилт **174**
- 5.6 Дэлхийн хотжилтын хандлага **174**
- 5.7 Дэлхийн том хотын бөөгнөрөл **175**
- 5.8 Их хотжилтын нутаг дэвсгэр, хүн амын тоо, нягтшил, 2020 **175**
- 5.9 Дэлхийн том агломерациуд **178**
- 5.10 Монгол улсын хот, хөдөөгийн хүн ам **186**
- 6.1 Байгалийн нөөц ба төрлүүд **197**
- 6.2 Эрдэс түүхий эдийн нөөц (улсаар) **198**
- 6.3 Бэлчээр ба тариалангийн талбай **204**
- 6.4 Хүн ам ба газрын нөөцийн харьцаа **204**
- 6.5 Цэнгэг усны нөөц **206**
- 7.1 Байршилд нөлөөлөх хүчин зүйлийн үнэлгээний жишээ **220**
- 7.2 Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарьт тэргүүлэгч улсууд **230**

* Зарим гарчгийг товчлов.

7.3	Кофе үйлдвэрлэлд тэргүүлэгч улсууд	234	10.8	Чингэлгийн тээвэрлэлтээр тэргүүлэгч боомт хотууд	344
7.4	Дэлхийн гадаад худалдаа, улсуудаар	235	10.9	Дэлхийн томоохон сувгууд	345
7.5	Дэлхийн томоохон ҮДК-ууд	236	10.10	Экспортод тэргүүлэгч орнууд	350
8.1	Загас агнуурын хэмжээ	255	10.11	Дэлхийн голлох экспортын бүтээгдэхүүний худалдаа	351
8.2	ХАА-н голлох таримлын хэмжээ	271	10.12	Дэлхийн шилдэг 10 банк	352
8.3	Үр тарианы экспортын хэмжээ, (мян.тонн)	281	10.13	Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	352
9.1	Түлшний олборлолтоор голлох орнууд	292	10.14	Олон улсын аутсорсингийн бүтэц	354
9.2	Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл	298	10.15	Аутсорсинг ба гэрээт ажлын ялгаа	355
9.3	Том усан цахилгаан станцууд	299	11.1	Улс төрийн хурцадмал голомт ба бүсүүд	362
9.4	Машин үйлдвэрлэл	309	11.2	ЭАИ-ээр тэргүүлэгч орнууд	365
9.5	Химийн үйлдвэр, улсуудаар	311	11.3	Дэлхийн хамгийн бохир 10 хот	366
9.6	Нэхмэлийн үйлдвэрлэл, улсуудаар	314	11.4	Зарим улс орны ашиглаж буй газар	369
10.1	Авто машины тоо	337	11.5	Ундны сайжруулсан усны хангамж багатай орнууд	377
10.2	Авто замын сүлжээ, улсуудаар	338	11.6	Гадаргын усны импортоос хамаардаг зарим улсууд	377
10.3	Төмөр замын уртаар тэргүүлэгч орнууд	339	11.7	Ус бохирдуулагч үйлдвэрлэлийн нөлөө	379
10.4	Төмөр замын тээврийн ачаа эргэлтээр тэргүүлэгч орнууд	340			
10.5	Төмөр замын зорчигч эргэлтээр тэргүүлэгч орнууд	340			
10.6	Дамжуулах хоолойн уртаар тэргүүлэгч орнууд	342			
10.7	Худалдааны боомт хотуудын даац	343			

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АЖИ	Аз жаргалын индекс	НТ	Нийтийн тоолол
АНУ	Америкийн Нэгдсэн Улс	НТӨ	Нийтийн тооллын өмнөх
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмирт Улс	НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АСЕАН	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо	НЭЗ	Нийгэм-эдийн засаг
АХБ	Азийн хөгжлийн банк	ОПЕК	Газрын тос экспортлогч орнуудын холбоо
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	ОУВС	Олон улсын валютын сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
БТД	Бизнесийн төв дүүрэг	ТАБНУ	Төв Африкийн Бүгд Найрамдах Улс
ГДТ	Газар дундын тэнгис	ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
ГМС	Газарзүйн мэдээллийн систем	ТУХН	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл
ДАЖБ	Дэлхийн аялал жуулчлалын байгууллага	ҮДК	Үндэстэн дамнанас корпораци
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан	ҮНО	Үндэсний нийт орлого
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ХАА	Хөдөө аж ахуй
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага	ХБО	Хөгжиж буй орнууд
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	ХО	Хөгжингүй орнууд
ЕХ	Европын холбоо	ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ЗТС	Зайнаас тандах судлал	ХХИ	Хүний хөгжлийн индекс
НАТО	Умард Атлантын цэргийн эвсэл	ШУТ	Шинжлэх ухаан, технологи
НАФТА	Хойд Америкийн чөлөөт худалдааны элэлцээр	ЭАИ	Экологийн ашигт индекс
		ЭЗХАХБ	Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)

ӨМНӨХ ҮГ

Манай хамт олон МУБИС-ийн Газарзүйн тэнхим үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойд зориулсан хоёр дахь сурах бичгээ гарган та бүхний гар дээр тавьж байна. Сургалтын үндэсний хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан агуулга бүхий энэхүү ном нь газарзүйн багш боловсролын үндсэн сурах бичиг болох ба багш бэлтгэх (pre service) болон төгсөлтийн дараах (in service) сургалтад зориулагдсан болно.

Газарзүйн шинжлэх ухаан 21 дүгээр зууны Тогтвортой хөгжлийн гурван тулгуур болсон БАЙГАЛЬ (ус, хөрс, уур амьсгал, байгалийн нөөц г.м), НИЙГЭМ (хүн ам, хэл, соёл, шашин, хотжилт, тэгш байдал г.м), ЭДИЙН ЗАСАГ (хөдөө аж ахуй, аж үйлдвэр, тээвэр, холбоо, аялал жуулчлалын орлого, үр ашиг, эрэлт нийлүүлэлт г.м)-ийн асуудлыг нутаг дэвсгэрийн хүрээнд судалж, орон зайн тархалтын учир шалтгаан, гарах үр дагаврыг хоорондох хамаарал, холбоо уялдаанд нь цогцоор авч үздэг. Энэ үүднээс Австрали, Япон зэрэг хөгжингүй орнууд газарзүйн сургалтад ихээхэн ач холбогдол өгч байна. Тус тэнхмээс өмнө нь гаргасан сурах бичгүүд тогтвортой хөгжлийн “гурвалжин”-гийн эхний хэсэг (*байгаль орчин*)-ийн шинжлэх ухааны зүй тогтлыг (*Дэлхий судлал*) өөрийн орны жишээн дээр буулган ойлгох (*Монгол орны физик газарзүй*) үндэс болсон билээ. Харин **Нийгэм-эдийн газарзүйн үндэс (Introduction to Human Geography)** хэмээх энэхүү сурах бичиг нь тогтвортой хөгжлийн бусад хоёр бүрэлдэхүүн болох *нийгэм* ба *эдийн засагт* хамаарах үндсэн суурь мэдлэгийг багтаасан болно.

Сурах бичгийн агуулга, арга зүйн дидактик боловсруулалтад дараах зүйлсийг харгалзав. Үүнд:

- Юуны өмнө газарзүйн судалгааны үндэс болох байгаль-нийгмийн хамаарлыг гаргахыг урьтал болгон хүн амын тархалт, суурьшилт, нийгмийн тулгамдсан асуудал, геополитик зэрэгт физик газарзүйн хүчин зүйлийн нөлөөг тодруулж оруулахыг зорьсон. Энэ нь газарзүйн сургалт төдийгүй судалгаанд ч баримтлах зарчимд нийцнэ хэмээн үзэв.
- Газарзүйн “алтан асуулт” гэгддэг ЮУ? (нийгмийн хөгжил, тэгш бус байдал, орлогын ялгаа, хүн амын тархалт, суурьшил, өөрчлөлт, үйлдвэрлэлийн салбар, байгалийн нөөц ба нийгмийн асуудлууд г.м), ХААНА? (хаагуур тархсан, дэлхийн аль хэсэгт, ямар улсад г.м), ЯАГААД? (шалтгаан) гэдэгт хариулах боломж олгохыг зорьсон.
- Энэ үүднээс орон зай-нутаг дэвсгэрийн тархалтыг аль болох газарзүйн зураг (хэл ба шашны тархалт г.м)-аар харуулж, дүрслэлийн олон төрөл (341 зураг, 89 хүснэгт)-өөр илэрхийлэхийг оролдсон. Иймд газарзүйн зургийн төрөл бүрийн тусгаг (Меркаторын, Робинсоны г.м), график, диаграммын янз бүрийн хэлбэр (гурвалжин, цэгэн тархалтат, баганан, тойргон, шугаман г.м) ашигласан нь багш боловсролын чухал хэсэг болох дидактик шийдэлд нэмэртэй болно.
- Уг сурах бичгийн агуулга, арга зүй нь газарзүйн сургалтын үндэсний хөтөлбөр, ЕБС-ийн “Газарзүй V, VI” сурах бичиг, багшийн ном (Е.Батчулуун ба бус, 2013, 2014)-той уялдсан, зарим хэсгийг ашиглаж баяжуулан, үндсэн эх сурвалжийг нь дурдсан.

- Улсуудын нэрийг “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-д бичсэнээр авав. Жишээ нь: *Финланд, Швейцар, Босни-Херцеговин г.м.*
- Орчуулгын зарим нэршлийн монгол утгыг харгалзан шинэчлэв. *Улс орнуудын зураг; Бодит нягтшил г.м.*
- Дэлгэрүүлж, тодруулах зарим хэсэгт “зүүлт” нэмсэн. Жишээ нь: *Спартли арал, Хормузын хоолой г.м.*

Номын агуулга, бүтцийг 11 бүлэгт багтаав. 1) *Эхний бүлэгт* нийгэм-эдийн засгийн газарзүйн ерөнхий ойлголт, судалгааны (ГМС, зайнаас тандан судлал) болон зураглалын аргуудын талаар; 2) *Хөгжлийн газарзүй* бүлэгт дэлхийн улс орнуудын газарзүйн онцлог, өөрчлөгдөж ирсэн байдал ба нийгэм-эдийн засгийн хөгжлийн ялгаа, нөлөөлөх хүчин зүйлс, баялгийн тэгш бус хуваарилалтын талаар; 3) *Хүн амын газарзүй* бүлэгт дэлхийн хүн амын өөрчлөлт, нас хүйсийн бүтэц, тархалт суурьшилтыг зарим бүс нутаг, улсаар жишээлэн; 4) *Соёлын газарзүй* бүлэгт соёлын хэв шинж, хэл ба шашны газарзүйн тархалт, үндэстэн угсаатны нутаг дэвсгэрийн онцлогийг; 5) *Хотын газарзүй* бүлэгт дэлхийн хотжилтын түүхэн байдал болон хот хөдөөгийн суурин газрын ялгаа, том хотууд болон монгол орны жишээг товч авч үзсэн. 6) *Байгалийн нөөцийн газарзүй* бүлэгт байгалийн нөөцийн ангилал ба орон зайн тархалтын ялгаа, нөлөөлөх хүчин зүйлийг зургаар баяжуулан оруулав. 7) *Үйлдвэрлэлийн газарзүй* бүлэг нь 8, 9, 10 дугаар бүлгийн оршил болох ба салбаруудын онцлог, ялгаа, ажиллах хүчний бүтцийн өөрчлөлт зэргээс гадна бараа бүтээгдэхүүний солилцоо, худалдааны явцад үүсэж буй олон улсын харилцаа, хөдөлмөрийн газарзүйн хуваарь, үйлдвэрлэлийн төрөлжилтийн талаарх ерөнхий ойлголтыг багтаасан болно. 8) *Үйлдвэрлэлийн анхдагч салбарын газарзүй* бүлэгт хөдөө аж ахуй болон олборлох үйлдвэрлэлийг; 9) *Үйлдвэрлэлийн хоёрдогч салбарын газарзүй* бүлэгт аж үйлдвэрийн төрөлжилт ба тархалтын талаар; 10) *Үйлдвэрлэлийн гурав ба дөрөвдөгч салбарын газарзүй* бүлэгт үйлчилгээ, тээвэр, харилцаа холбоо болон аялал жуулчлалын нутаг дэвсгэрийн ялгаа, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар; 11) *Байгаль-нийгмийн асуудлууд, тогтвортой хөгжил* бүлэгт байгаль-нийгмийн харилцааны үндсэн дээр үүсэж буй тулгамдсан асуудлаас заримыг тодотгон газарзүйн үүднээс авч үзсэн болно.

Уг сурах бичгийг хэвлэхэд дэмжлэг үзүүлсэн МУБИС-ийн захиргаа, хэвлэлийн эх, зураг бэлтгэхэд сэтгэл гарган ажилласан Б.Бүжидмаа, туслах ажилтан Г.Ууганбат, төгсөгч Г.Бадмаанямбуу нарт талархал илэрхийлье.

Газарзүйн ухааны доктор, профессор



Ембүүгийн БАТЧУЛУУН

Цахим шуудан: batchuluun@msue.edu.mn

Утас: 9909-1640

*Х.Цогбадрал
П.Энхжаргал
Ц.Бат-Эрдэнэ*

Зорилго


1. Нийгэм-эдийн засаг (НЭЗ)-ийн газарзүйн салбар шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны аргуудтай танилцах;
2. Зурагзүйн дүрслэлийн аргууд ба гео-орон зайн технологи ашиглан НЭЗ-ийн юмс үзэгдлийн газарзүйн тархалтын зүй тогтол, харилцан хамаарлыг тайлбарлах;
3. Сэдэвчилсэн газарзүйн зураг унших, анализ хийх, дүгнэлт гаргах замаар байгаль-нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ашиглах;

Хураангуй

НЭЗ-ийн газарзүй бол газарзүйн шинжлэх ухааны хоёр том салбарын нэг бөгөөд хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдөж буй байгалийн нөхцөл, нөөц, тэдгээрийн хоорондын хамаарлыг судална. Энэ бүлэгт НЭЗ-ийн газарзүйн салбар ухааны хөгжлийн тойм, хандлага, судлах зүйл, мэдээллийн эх үүсвэр, судалгааны арга зүйн талаар нэгтгэн авч үзсэн болно. НЭЗ-ийн үзэгдэл, юмсыг зураглах, зурагзүйн дүрслэлийн үндсэн аргуудын онцлог, төрөл, ялгааг судалгаанд хэрэглэх байдлыг тоймлон дурдаж жишээгээр тайлбарлав. Бүлгийн сүүлийн хэсэгт НЭЗ-ийн газарзүйн судалгаанд орчин үед хэрэглэгдэх болсон зайнаас тандах судлал, ГМС-ийн зураглалын зэрэг аргуудыг товч дурьдсан болно.

Түлхүүр үгс: Сэдэвчилсэн зураг, агаар, сансрын зураг, зурагзүйн дүрслэл, гео-орон зайн технологи

Keywords: Thematic map, Aerial and satellite images, Cartographic representation, Geospatial technology



Зураг 1.8 Зурагзүйн дүрслэлийн аргууд

Е.Батчулуун

Зорилго

1. Улс орнуудын ялгаа, түүнд нөлөөлөх хүчин зүйлс ба шалтгааныг судлах;
2. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг газарзүйн байрлал, уур амьсгал, байгалийн нөхцөл, хүн ам зүйн үүднээс авч үзэн жишээн дээр тулгуурлан дүгнэлт гаргах;
3. Баялгийн хуваарилалтын ялгааг нийгэм-эдийн засгийн болон хүний хөгжилтэй холбон тайлбарлах;

Хураангуй

Энэ бүлэг нь дэлхийн улс орнуудын хил хязгаар, нутаг дэвсгэрийн өөрчлөлтийн түүхэн байдал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн ялгаа, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг газарзүйн талаас нь авч үзсэн “Дэлхийн улс орнууд”, “Хөгжил ба тэгш бус байдал” гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Холбогдох тоо баримтыг Олон улсын валютын сан, Дэлхийн Банк болон НҮБ-аас жил бүр гаргадаг эх сурвалжаас авав. Хөгжил бол дан ганц материаллаг талаасаа биш, амьдралын чанар, сэтгэл ханамжийн үзүүлэлтээр хэмжигдэх тул Хүний хөгжлийн индекс, Ядуурлын индекс, Аз жаргалын индекс зэрэг хөгжлийн индексийн талаар цухас дурдав. Улс орнуудыг хөгжлийн түвшнээр нь янз бүрээр ангилдаг, энэ нь тухайн судалгааны байгууллага, судлаачдын баримталдаг байр сууриас хамаарахаас гадна улс орны хөгжлийн хурдац зэргээс хамаарч “өөрчлөгдөж” байдаг тул “туйлын” утгаар нь ойлгох боломжгүй юм. Иймд нийгэм-эдийн газарзүйн тулгуур эх сурвалжуудад түгээмэл ашиглаж буй ангиллыг энд голлон авав. Бүлгийн сүүлийн хэсэгт баялаг ба орлогын хуваарилалтын ялгааг авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнууд, Буурай хөгжилтэй орнууд, Бүс нутаг, Хүний хөгжлийн индекс

Keywords: More economically developed countries (MEDCs), Less economically developed countries (LEDCs), Regions, Human development index

Е.Батчулуун (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: batchuluun@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс


Йордан, Кувейт) хэмээн ялгагдана. Гэвч хаант засаглалтай улсын ихэнх нь үндсэн хуульт буюу хязгаарлагдмал хэлбэртэй. Энд хамаарах Бельги, Англи, Дани, Люксембург, Нидерланд, Норвег, Швед, Япон зэрэг улсад хууль ёсны засгийн эрхийг парламент барьж, засгийн газар ажиллах ба хаан нь үндсэн хуульдаа захирагдан төлөөллийн үүрэг гүйцэтгэхээс гадна уламжлалаа хадгалж, улс орны амьдралд идэвхтэй оролцдог.

Хаант ба бүгд найрамдах засаглалтай улсын аль нь ч **шашин төр хосолсон**⁸ хэлбэртэй байж болно. *Хаант улсуудаас* Марокко, Йордан, Саудын Араб, Оман, Ватикан, Бруней улс; *Бүгд найрамдах улсуудаас* Иран, Йемен, Пакистан, Судан

улс ийм засаглалтай. Шашин төрийг хосолсон эдгээр улсын тэргүүн нь шашны төлөөлөгч байдаг онцлогтой.

Улс орнууд сайн дурын үндсэн дээр нэгдэн **хамтын нөхөрлөл** байгуулдаг бөгөөд гарах эрх нь нээлттэй, бүгд найрамдах ба хаант засаглалын аль аль нь байж болно. Жишээ нь: Их Британи улс өөрийн колони байсан улсуудтай нэгдэн байгуулсан хамтын нөхөрлөлд 16 улс (Канад, Австрали, Шинэ Зеланд г.м) ордог бөгөөд Английн хатан хааныг улсынхаа тэргүүн гэж үздэг. Хамтын нөхөрлөлийн орнууд боловсрол, шинжлэх ухаан, худалдаа зэрэг салбарт хамтран ажиллах, зарим хөнгөлөлт эдлэх боловч гадаад дотоод асуудлаа бие даан шийдвэрлэнэ.

⁸ theocratic state



Зураг 2.3 Улс орнуудын төрийн тогтолцоо (Эх сурвалж: Diercke International Atlas, 2010)

Хүснэгт 2.12 Хүний хөгжлийн индексээр тэргүүлэгч орнууд (2007, 2011, 2018)

№	Улсын нэр	ХХИ (2007)	Улсын нэр	ХХИ (2011)	Улсын нэр	ХХИ (2018)
1	Норвег	0.971	Норвег	0.943	Норвег	0.953
2	Австрали	0.970	Австрали	0.929	Швейцар	0.944
3	Исланд	0.969	Нидерланд	0.910	Австрали	0.939
4	Канад	0.966	АНУ	0.910	Ирланд	0.938
5	Ирланд	0.965	Шинэ Зеланд	0.908	Герман	0.936
6	Нидерланд	0.964	Канад	0.908	Исланд	0.935
7	Швед	0.963	Ирланд	0.908	Хонконг	0.933
8	Франц	0.961	Лихтенштейн	0.905	Швед	0.933
9	Швейцар	0.960	Герман	0.905	Сингапур	0.932
10	Япон	0.960	Швед	0.904	Нидерланд	0.931
115	Монгол	0.727	110. Монгол	0.653	92.Монгол	0.741

HPI-1 ангилалд, Олон улсын хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ОЕС-Д)-ын гишүүн орнууд өндөр орлоготой буюу HPI-2 ангилалд орно.

Хүн амын ядуурлын индекс 1) 60 хүрэхээс өмнө нас барж буй хүн амын эзлэх хувь, 2) функциональ бичиг үсэггүй насанд хүрэгчдийн эзлэх хувь, 3) ядуурлын түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь, 4) урт хугацааны ажилгүйдлийн түвшин (12 сар ба түүнээс дээш) зэргийг тооцож үзнэ. Жишээ нь: 40-өөс доош насны хүмүүсийн нас баралтын түвшин нь эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байгааг илэрхийлнэ. Хэрэв бичиг үсэг үл мэдэгдчдийн хувь өндөр бол ажилгүйдэл их байгааг илтгэнэ.

НҮБ-аас 2011 оноос **Ядуурлын олон хэмжээст индекс**³⁰ хэрэглэх болсон ба эрүүл мэнд, боловсрол, амьдралын стандарт гэсэн гурван хэмжигдэхүүнд хамаарах 10 үзүүлэлтээр тооцно. Үүнд: **1)** Сургуулийн хамран сургалт, **2)** Суралцсан жил буюу 5 хүртэл жил сургуульд сурсан эсэх, **3)** Нярайн эндэгдэл, **4)** Хоол хүнсний хангамж, **5)** Материаллаг хэрэгцээ, **6)** Ариун цэврийн нөхцөл, **7)** Ундны усны хангамж, **8)** Орон байр, **9)** Түлшний хангамж, **10)** Эрчим хүчний хангамж, зэрэг болно (Хүснэгт 2.13).

³⁰ Multidimensional Poverty Index (MPI)

Хүснэгт 2.13 Ядуурлын олон хэмжээст индекст ашиглах үзүүлэлтүүд³¹:

	10 үзүүлэлт
Боловсрол (үзүүлэлт болгон 1/6-тэй тэнцэнэ)	Суралцсан жил (5 хүртэл жил суралцсан эсэх)
	Сургуульд хамрагдалт (8-р анги хүртэл сурсан эсэх)
Эрүүл мэнд (үзүүлэлт болгон 1/6-тэй тэнцэнэ)	Хүүхдийн нас баралт
	Хоол тэжээлийн байдал
Амьдралын стандарт: (үзүүлэлт болгон 1/18-тэй тэнцэнэ)	Гэрэл, цахилгаан
	Ариун цэврийн хангамж
	Ундны усны хангамж
	Орон байр
	Хоол хийх түлш
	Эд хогшил (радио, телевиз, хөргөгч г.м.)

Дээрх үзүүлэлт 33.33 хувь, түүнээс доош байвал ядуу гэж үзнэ. Гэвч улс орон болгон хоорондоо ялгаатай. Ялангуяа гуравдагч ертөнцийн улсууд хоорондоо бүр ч их ялгаатай бөгөөд нийтлэг тал нь хүн амын ихэнх хэсгийн амьдралын түвшин доогуур байдаг оршино.

³¹ Alkire, et.al. (2011): Brief Methodological Note". Oxford Poverty & Human Development Initiative (OPHI)

Е.Батчулуун

Зорилго

1. Хүн амын газарзүйн ойлголтыг эзэмшин, нутаг дэвсгэрийн ялгааг судлах;
2. Хүн амын тоо, өсөлт, нягтшил, суурьшилтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, тайлбарлах;
3. Холбогдох тоон мэдээлэл ашиглан хүн амын газарзүйн асуудлуудыг судлан, зураглах, дүгнэлт гаргах;

Хураангуй

Хүн амын газарзүй бол хүн ам зүй ба газарзүйн шинжлэх ухааны зааг болох салбар шинжлэх ухаан юм. Энэ нь хүн амын өөрчлөлт, суурьшил, шилжилт хөдөлгөөнийг орон зайн үүднээс авч үзэн учир шалтгааныг судалдаг. Энэ бүлэгт дэлхийн хүн амын тоо, өсөлт, нийгмийн хөгжлийн хамаарал, тархалт суурьшил, шилжилт ба тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлсийн талаар дурдана. Холбогдох тоон мэдээллийг боловсруулахдаа НҮБ-ын Хүн амын сан, Хүн амын хэлтэс, Дэлхийн Банк зэрэг голлох байгууллагын цахим сангаас аль болох сүүлийн оныхоор авахыг зорьсон ба тухайн улс орон, бүс нутгийн хүн амын өөрчлөлт, бүтэц бүрэлдэхүүн, төрөлт ба нас баралтын коэффициент, төрөлтийн түвшин, нас хүйсийн суварга зэргийг тухай бүрт нь дурдсан холбоосыг ашиглан авах боломжтой.

Түлхүүр үгс: Хүн амын өөрчлөлт
Нас хүйсийн пирамид, Шилжих
хөдөлгөөн, Хүн амын насжилт


Keywords: Population change,
Population pyramid, Migration,
Ageing population

Е. Батчулуун (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим

e-mail: batchuluun@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс



Зураг 3.21 Хүн амын дундаж наслалт, улсаар (Эх сурвалж: UN Population Division, 2019: <https://ourworldindata.org/life-expectancy>)

Наслалт хамгийн өндөр (20 улс)	Наслалт хамгийн богино (20 улс)
Хонконг 85.3	Гамби 63.0
Япон 85.0	Буркина Фасо 63.0
Макао 84.7	Бенин 62.8
Швейцар 84.3	Бурунди 62.7
Сингапур 84.1	Гвиней 62.6
Итали 84.0	Ангол 62.2
Испани 84.0	Зимбабве 62.2
Австрали 83.9	Того 62.1
Исланд 83.5	Мозамбик 62.1
БНСУ 83.5	Ард.Конго 61.6
Израил 83.5	Мали 60.5
Швед 83.3	Камерун 60.3
Мартини 83.1	Эк.Гвиней 59.8
Франц 83.1	Гвиней-Бисау 59.4
Мальта 83.1	Кот'д Ивуар 58.8
Канад 83.0	Өмнөд Судан 58.7
Норвег 82.9	Сомали 58.3
Ирланд 82.8	Сьерра Леоне 55.9
Шинэ Зеланд 82.8	Нигери 55.8
Грек 82.8	Лесото 55.7
Люксембург 82.8	Чад 55.2
Нидерланд 82.8	ТАБНУ 54.4

Хүснэгт 3.5 Хүн амын дундаж наслалтын ялгаа (Эх сурвалж: 2020 World Population Data Sheet, Population Reference Bureau: <https://www.worldometers.info/demographic/>)

20 дугаар зууны 2 дугаар хагасаас хойш дэлхийн хэмжээгээр, ялангуяа хөгжиж буй орнуудад эрүүл мэндийн хувьд ихээхэн ахиц гарсны үр дүнд нялхсын эндэгдэл буурч байна. Энэ үзүүлэлт дэлхийн дунджаар 1,000 хүүхдэд 41, хөгжингүй орнуудад 5, хөгжиж буй орнуудад 45, Африкийн Либери, Нигери, Сьерра-Леон, Азийн Афганистан зэрэг нэн ядуу оронд 100-120 орчим байна.

Хүн амын амьдралын чанарын нэг үзүүлэлт бол *бичиг үсэгт тайлагдсан байдал* юм. Өндөр хөгжилтэй болон хуучин социалист системийн орнуудын ихэнхэд насанд хүрэгчдийн (15 ба түүнээс дээш) 95.0 ба түүнээс дээш хувь нь бичигт үсэгт тайлагдсан бол хөгжиж буй зарим оронд одоо хүртэл доогуур байна. 1820 онд дэлхийн хүн амын дөнгөж 12 хувь нь бичиг үсэг мэддэг

*Е.Батчулуун
Х.Цогбадрал*

Зорилго

1. Соёлын газарзүйн үндсэн ухагдахуунтай танилцаж, бүрэлдэхүүн хэсгүүдийн орон зайн тархалтыг судлах;
2. Дэлхийн голлох хэл ба шашны газарзүйн онцлог, тархалтыг харьцуулах, шалтгааныг тайлбарлах;
3. Соёлын олон талт байдлыг харьцуулан, харилцан ойлголцлын талаар дүгнэлт гаргах;

Хураангуй

Энэ бүлэгт соёлын голомт, мужлал, бүрэлдэхүүн хэсгийн талаар үндсэн ойлголт өгч хэл ба шашны ялгаа, нутаг дэвсгэрийн тархалтад тулгуурлан газарзүйн талаас нь авч үзэхийг зорьсон болно. Хэлний аймаг, язгуур, тэдгээрт багтах бүлэг ба дэд бүлэг хэлний тоо зэргийг “хатуу” тогтоох аргагүй тул их, дээд сургуулийн газарзүйн үндсэн сурах бичгүүдэд түгээмэл хэрэглэдэг ангиллыг гол болгон авав. Өргөн хүрээтэй энэ ухагдахууныг тэр бүр багтаах боломжгүй тул нутаг дэвсгэр, тархалтыг дүрсэлсэн газарзүйн зургийг ашиглан нэмэлт мэдээлэл авах боломжтой юм. Соёлын газарзүйн ялгаа, ижилсэл, ондоошлын цаад мөн чанар нь дэлхийн хүн амын үндэстэн, угсаатны бүтэц бүрэлдэхүүн, амьдарч буй нутаг оронтой холбоотой тул бүлгийн сүүлийн хэсэгт энэ талаар товч оруулав.

Түлхүүр үгс: Соёлын ялгаа
Хүн амын угсаатны бүтэц
Хэлний газарзүй Шашны газарзүй

Keywords: Cultural differences,
Ethnic classification, Language
geography, Religion geography

хэлийг албан ёсны хэл гэж үздэг бол Ангол ба Мозамбик улсын албан ёсны хэл нь португали юм.

Номхон далайн арлын улсуудын ихэнх нь Европын аль нэг хэлийг албан ёсны хэл болгосон байдаг. Албан ёсны хоёр хэлтэй Канад ба Финланд, гурван хэлтэй Боливи, Бельги, 4 хэлтэй Сингапур гэх мэт олон хэл (multilingual)-ээр онцгойрдог улсууд ч бий. Өмнөд Африкийн БНУ үндсэн хуулиндаа 11 хэлийг албан ёсных хэмээсэн бол Энэтхэг улсад үндэсний бус, мужийн түвшинд албан ёсны статустай 18 хэл бий.

Олон хэлтэй улсад соёлын ба орон зайн хуваагдал үүсэх нь бий. Канадад 1969 онд батлагдсан албан ёсны хэлний бодлогоор франц ба англи хэлийг эрх тэгш статустай хэмээн үзсэн боловч франц хэлтэн Квебек мужид бөөгнөрч, бусад газраа амьдардаг англи хэлтэн хүмүүсийн хооронд мэдэгдэхүйц соёлын ялгаа үүсгэдэг. Түүгээр ч үл барам Квебек мужид салан тусгаарлах хөдөлгөөн үүсэж, бүх нийтийн санал асуулга явуулсан билээ. Канадын хойд нутгийн уугуул оршин суугчдын хэлний онцлогийг харгалзан дээрх 2 хэл дээр 6 уугуул хэлийг нэмж, тус улс нийтдээ албан ёсны 8 хэлийг хуульчилжээ. Албан ёсны *ганц хэлтэй (monolingual)* харьцангуй цөөн улсын нэг нь Монгол юм.


Албан ёсны хэл нь англи боловч амьдарч буй үндэстэн, ястнаас хамааран “албан бус” олон төрлийн хэлийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг улс олон. Тухайлбал, олон үндэстэн холилдон амьдардаг АНУ-ын албан хэл англи боловч өөр олон хэл ашигладаг. Тус улсын 40 орчим муж улсад жолооны шалгалтын тестийг олон гадаад хэл дээр (Калифорнд 30, Нью-Йоркд 23, Мичиганд 20 хэл) авдагийн дотор араб финн хэл ч орно. АНУ-ын хүн амын 18 хувь нь гэртээ англиас өөр хэлээр

ярьдаг бөгөөд зөвхөн Калифорнд гэхэд л сургуулийн 3 хүүхдийн нэг нь англиас өөр хэлтэй гэр бүлийнх байдаг. Нийслэл хотын сургуулиудад 127 төрлийн хэл ба аялгаар ярьдаг тооцоо гарчээ. Иймд 1960-аад оноос эхлэн хос хэлний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна.


Дэлхий дээр ярьж буй хүний тоогоор үзвэл өргөн хэрэглэгддэг хэл нь *хятад, испани, англи, бенгал, хинди, урду, араб, португал, орос, япон, герман ба франц* болно⁸. Эдгээрээс 200 саяас олон хүн ярьдаг хэлийг *НҮБ-ын албан ёсны хэл* хэмээн зарласан ба энэ нь *англи, франц, испани, араб, хятад, орос* гэсэн 6 хэл юм. Олон улсын түвшний ажил хэрэгт хэрэглэгдэх ач холбогдлоор хамгийн эхэнд англи, дараа нь франц, испани орно. 2020 оны байдлаар англи хэл 80 улс, испани 58, франц 32, араб 26 улсын албан ёсны хэл болж байна. Орос хэл нь ОХУ, Беларусь, өмнөд Осетинээс гадна Украин, Киргиз, Абхаз болон Украин, Румын, Молдавийн зарим мужид улсын байгууллагуудад хэрэглэгддэг (*Зураг 4.11*).

Англи хэл бол хэлний өөрчлөлтийн үр дүнд үүссэн, герман гаралтай хэл юм. Орчин цагийн англи хэл нь эртний Англи буюу Англо-Саксон хэлний нэг аялга байдлаар үүсч, НТ 5 дугаар зууны үед Британид нэвтэрч латин болон франц хэлний норманд аялгаар баяжин хөгжжээ. Британчууд 1362 онд франц хэлийг халж, англи хэлийг албан ёсны хэл болгожээ. Ингэснээр англи хэл Европоос хальж бүх тивд тархан, дэлхийн хамгийн түгээмэл хэл болсон ба эдүгээ 1.5 тэрбум хүн ярьж байна. Хэл зүйч Самуэл Жонсон (1709-1784) “стандарт дүрэм”-ийг боловсруулснаар орчин цагийн англи хэл төгөлдөржсөн гэж үздэг.

⁸ <https://www.mapsofworld.com/world-language-map.htm>



Зураг 4.11 Албан ёсны хэлний газарзүйн тархалт (Эх сурвалж: Diercke International Atlas, 2010)



Зураг 4.12 Англи хэлний газарзүйн тархалт
(Эх сурвалж: <https://commons.wikimedia.org/wiki/File:Anglospeak>)

Ц.Бат-Эрдэнэ

Зорилго

1. Хүн амын суурьшлын хэлбэр, хот, түүний хөгжлийн үеүдийг тайлбарлах;
2. Хотын орон зайн бүтэц, хэлбэрүүдтэй танилцах;
3. Хотжилтын ялгаа ба бүс нутаг, улс орнуудын хөгжлийн түвшний хамаарлыг тайлбарлах;
4. Хотжилтын төлөв, хандлагыг бүс нутгуудаар ялгаатай болохыг тодорхойлох;

Хураангуй

Хот нь хүн ам бөөгнөрөн суурьшсан бага хэмжээний газар нутаг бөгөөд тэнд оршин суугчдын нийгэм, соёл, аж ахуйн бүхий үйл ажиллагааны цогц системийг бүрдүүлж байдаг. Дэлхийн хүн ам, эдийн засаг өсөхийн хэрээр хотууд хурдацтай өргөжин тэлж, Ази, Африкийн хөгжиж буй орнуудад өсөлтийн зонхилох хувь ногдож байна. Хүн амын суурьшил, хэлбэр, хотын тухай тодорхойлолтууд, түүний орон зайн бүтцийн талаар бүлгийн эхний хэсэгт авч үзсэн ба хотын хөгжлийн түүхэн үе шатуудыг бүлгийн дараагийн хэсэгт өгүүлсэн. Бүлгийн сүүлийн хэсэгт хотжилтын түүхэн өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, цаашдын хандлага, бүс нутгууд дахь орон зайн ялгааны талаар авч үзлээ. Мөн манай орны хотжилтын тухай товч дурьдсан болно.

Түлхүүр үгс: Суурьшлын хэлбэр, хот ба хөдөөгийн суурьшил, суурьшлын шатлал, хотжилт, хотжилтын түвшин

Keywords: Settlement type, urban and rural settlement, settlement hierarchy, urbanization, urbanization rate

Ц. Бат-Эрдэнэ (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: batedene@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс

Ийм байдлаар тооцож үзвэл, Канадын Торонто хотын хил дотор 2011 онд ойролцоогоор 2.6 сая хүн оршин сууж байсан бол ойролцоох хотын бөөгнөрөл буюу агломерацид нь бараг хоёр дахин их буюу 5.1 сая, харин «их хотын бүс»-д 5.6 сая хүн оршин сууж байжээ.

Хотуудыг олон янзаар ангилдаг ч хүн амын тоо, гүйцэтгэх үүргээр нь ангилах ангилал голлодог байна (Хүснэгт 5.2-д түүвэрлэн харуулав). Тухайн улс, бүсийн

төр, засгийн газар нь байрладаг засаг захиргааны төвийн үүрэг гүйцэтгэдэг хот, суурин газрыг нийслэл хот гэж нэрлэнэ.

Тухайн улсын эдийн засгийн голлох салбарууд болох банк, бирж, аж үйлдвэр, зам тээврийн төвүүд, шинжлэх ухааны байгууллагууд байрладаг нийслэл хотууд олонх боловч Исламабад (Пакистан), Канберра (Шинэ Зеланд) зэрэг зөвхөн засаг захиргаа, улс төрийн үүргийг гүйцэтгэдэг нь ч цөөнгүй бий.

Хүснэгт 5.2 Хотыг ангилах шалгуурууд

Ангилал шалгуур	Ангилал
Хүн амын тоогоор:	<ul style="list-style-type: none"> • Жижиг хот- 50 мян. хүртэлх хүн амтай • Дундаж хот- 50 мян.- 100 мян. хүн амтай • Том хот- 100 мян.- 250 мян. хүн амтай • Их хот- 250 мян.- 500 мян. хүн амтай • Маш том хот- 500 мян.- 1 сая хүн амтай • Саятан хот- 1 саяас дээш хүн амтай
Эдийн засгийн газарзүйн байрлалаар:	<ul style="list-style-type: none"> • Тээврийн замын огтлолцлын цэг дээр байрладаг хот • Томоохон уул уурхайн бүсэд байрладаг хот; • Томоохон боловсруулах үйлдвэрийн бүсэд байрладаг хот; • Эрчимжсэн хөдөө аж ахуйн бүсэд байрладаг хот; • Боомт хот
Аж ахуйн онцлогоор:	<ul style="list-style-type: none"> • Олон үйлдэлт (засаг захиргаа болон улс төр, соёл, эдийн засгийн хосолсон бүтэцтэй (нийслэл бас олон том хотууд)) • Бусад зонхилох бүтэцтэй хот (үйлдвэрлэлийн, тээврийн зэргээс бусад) ихэвчлэн жижиг засаг захиргааны төвтэй анхан шатны байгууллага • Амралт, сувиллын хот • Шинжлэх ухааны мөн шинжлэх ухааны туршилтын төв

5.3 Хотын орон зайн бүтэц, хэлбэр

Хотын орон зайн төлөвлөлтийг хийхдээ тухайн хотын хэмжээ, төлөвлөлтийн төвүүд, тэнхлэгүүд, бүсүүд, байгалийн ландшафтын төрх, хотын үүрэг, тээврийн болон эдийн засгийн байгуулалт, түүхэн уламжлал зэрэг нийгэм, байгаль газарзүйн нөхцөл нөөцийг харгалзан үздэг.

Төлөвлөлтийн бүтцийн эдгээр элемент тус бүр нь түүний нөлөөллийн шинж

чанарын дагуу өөрийн нөлөөллийн бүсийг бий болгож байдаг. Функциональ бүсчлэл нь юуны түрүүнд хотын өөр өөр хэсгүүдийн хэрэглээний ялгааг харуулдаг бол хотын төлөвлөлтийн бүтэц нь функциональ бүсүүд болон тэдгээрийн хоорондох холболтын системийн харилцан хамаарлыг илэрхийлнэ. Хотын орон зайн төлөвлөлтийн бүтэц нь түүний хэмжээ, хотын тээврийн бүтцийг хэрхэн байгуулахаас ихээхэн хамаардаг. Тээврийн дэд бүтэц нь зөвхөн хотын

5.5.2 Хотжилтын хандлага

Хотжилтын хөгжлийн орчин үеийн нэг хэв шинж бол буюу **захын дүүргийн хотжилт (suburbanization)** юм. Энэ нь хүмүүс хотжилтын нөлөөгөөр бий болсон дуу чимээ, агаарын бохирдол, ногоон байгууламжийн дутагдал зэргээс шалтгаалж томоохон хотоос дайжин, хот орчмын тав тухтай бүсэд нүүн

суух суурьшлын нэг хэлбэр юм. Гэхдээ тэдгээр хүмүүс бүгд хотод өөрийн ажлаа үргэлжлүүлэн эрхэлдэг байна. Цаашид уг суурьшлын бүсэд дэлгүүр, худалдаа, үзвэр, үзэсгэлэн, амралт зугаалгын үйлчилгээ нэвтэрч эхэлдэг. Хотын захын дүүргийн хөгжилтөнд нөлөөлсөн гол хүчин зүйл бол хүн бүр автомашин эзэмшиж эсвэл хоорондоо хамтран ашиглах боломжтой болсон явдал юм.



Зураг 5.18 Лас Вегас хотын захын дүүргийн хотжилт, АНУ, Невада муж
(Эх сурвалж: <https://www.britannica.com/topic/suburb>)

Хөдөөд хотын амьдралын хэв маяг тархах үзэгдлийг **рурбанизаци (rurbanization)** буюу хөдөөгийн хотжилт гэж нэрлэдэг. Орчин үед хөгжингүй орнуудын бараг бүх тосгоны оршин суугчид хотын соёл, иргэншлийн ашиг шимийг томоохон

хотын иргэдийн адил хүртэн амьдрах боломжтой болжээ.

Конурбац (conurbation) нь хүн амын өсөлт, хотын тэлэлтийн нөлөөгөөр, хэд хэдэн хот, томоохон суурин газрууд болон бусад хот, суурин газрууд хоорондоо хил

С.Хадбаатар

Зорилго

1. Байгаль-нийгмийн харилцан хамаарлыг байгалийн нөөц баялгийг ашиглахтай холбон авч үзэх, тэдгээрийн эдийн засгийн газарзүйн ухагдахуун талаас тодорхойлох;
2. Улс орнуудын хөгжлийн ялгаатай байдалтай холбон дүгнэлт гаргах, ялгааг тодорхойлох харьцуулан судлах;
3. Байгалийн нөөцийн тархалтын зүй тогтлыг тайлбарлах, улс орнуудын эдийн засгийн хөгжилд нөлөөлөх байдал, аж ахуйн ач холбогдлыг тодорхойлох;

Хураангуй

Байгаль орчныг танин мэдэх, нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэхэд газарзүйн шинжлэх ухаан ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Байгалийн нөөцийн тархалт, ашиглалттай холбоотой бүхий л үйл явц нэг талаас зах зээлийн эрэлт хэрэгцээ нөгөө талаас байгалийн баялгийг ашиглах гэсэн байнгын холбоонд оршино. Аж үйлдвэр, зам тээвэр, харилцаа холбоо, үйлчилгээ, батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, гэр ахуй, техник, технологийн зэрэг бүхий л салбарт байгалийн нөөцийг ашиглах хэрэглээ улам өссөөр байна. Эрдэс түүхий эдийн эрэлт хэрэгцээ, техник технологийн эрчимтэй хөгжил зэрэг нь далай, тэнгисийн ёроол, туйлын бүс, өндөр уулс, элсэн цөл гэх мэт нутгийг эзэмших нөхцлийг бий болгож газарзүйн бүрхэвчийн хувьсал өөрчлөлтөд нөлөөлж байна. Иймээс байгалийн нөөц нь хүн-байгаль-нийгэм гэсэн хүрээнд хүн амын өсөлт, эдийн засгийн хөгжилтэй нягт холбоотой. Энэ бүлэгт байгалийн нөөцийн газарзүйн тархалт, байршилт, ашиглалтыг улс орон, бүс нутгийн хүрээнд авч үзэв.

Түлхүүр үгс: Байгалийн нөхцөл, Нөөцийн ангилал, Нөхөн сэргээгдэх ба сэргээгддэггүй нөөц, Ашиглалт, Олборлолт, Боловсруулалт

Keywords: Natural condition, Classification of natural resources, Renewable and nonrenewable resources, Mining, Natural resources use

С.Хадбаатар (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: khadbaatar@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс

ихээхэн тархалттай ба цагаан тугалга (Малайз, Индонез, Тайланд), төмөр (Япон, Канад, Шинэ Зеланд) алт (АНУ, Канад) бокситын (Австрали) нөөц их. Австрали (илменит, циркон, рутил), Энэтхэг, Шри Ланка (илменит, монацит, циркон), АНУ (илменит, монацит), Бразил (монацит), Намиби, Ангол (алмаз) далайн эргийн бүсийн хүнд металлын шороон ордын нөөцтэй. Фосфоритийн томоохон ордууд АНУ, Африк, Өмнөд Америкийг хүрээлсэн шельфээр их тархсан.

Хүдрийн ашигт малтмалаас ферромарганцын ордыг 100 гаруй жилийн өмнө Английн далай судлалын экспедиц (Challenger) анх нээсэн. Түүнээс хойш ОХУ-ын (Витязь, Академик Курчатов, Дмитрий Менделеев) зэрэг далайн экспедицүүд судалгаа хийж ийм ордууд Кар, Баренцын тэнгисийн далайн гүн ховил, хотгоруудаар 100-7000 м-ийн гүнд байгааг тогтоожээ. Эдгээр ордод манган, төмөр, никель, кобальт, зэс, титан, молибден зэрэг холимог металлын хүдрүүд ч байдаг (Зураг 6.4).

Хүснэгт 6.2 Эрдэс түүхий эдийн нөөц, улсаар

Эрдэс, түүхий эдийн төрөл	Нөөц ихтэй улс
Газрын тос	Саудын Араб, Ирак, Кувейт, АНЭУ, Иран, Венесуэл, ОХУ, Ливи, АНУ
Байгалийн хий	Орос, Иран, Катар, Саудын Араб, АНЭУ, АНУ, Алжир, Венесуэл, Нигери, Ирак
Чулуун нүүрс	Хятад, АНУ, Орос, Австрали, Герман, Их Британи, Энэтхэг, ӨАБНУ, Польш, Украин, Канад
Төмрийн хүдэр	Бразил, Орос, Канад, Хятад, Австрали, Украин, АНУ, Казахстан, Энэтхэг, ӨАБНУ
Марганцын хүдэр	ӨАБНУ, Австрали, Габон, Бразил, Энэтхэг, Казахстан, Хятад
Хромын хүдэр	ӨАБНУ, Зимбабве, Энэтхэг, Турк, Филиппин, Иран, Канад, Бразил
Хөнгөнцагааны хүдэр	Гвине, Бразил, Австрали, Ямайка, Суринам, Гайана
Зэсийн хүдэр	Чили, АНУ, Хойд Солонгос, Замби, Перу, Австрали, Казахстан, Хятад
Цагаан тугалганы хүдэр	Малайз, Бразил, Индонез, Хятад, Боливи, Орос
Фосфорын хүдэр	Марокко, АНУ, Тунис, Австрали, Баруун Сахар, Египет, Бразил

Металл ашигт малтмал. Аж ахуй, үйлдвэрлэлд хэрэгцээтэй химийн нэгдэл буюу эрдсүүд агуулсан чулуулгийг хүдэр гэх ба ихэвчлэн металл ашигт малтмалын төрлүүд дээр хэрэглэнэ. Хүдрийн чанарыг ашигт нэгдлүүдийн агуулга, эрдсийн бүрэлдэхүүнээр тодорхойлно. Хар, өнгөт, үнэт, холимог, цацраг идэвхит, сарнимал, ховор гэх мэт ангилах ба шинж чанар, үйлдвэрлэлд ашиглагдах байдлаар ялгаатай. Төмрийн хүдрийг агуулгаар нь

их, дунд, бага гэж үзэх бөгөөд 45 хувиас дээш бол баяжуулалтгүй боловсруулна. Металлын хүдэр нь ган хайлуулах, төмөр, ширэм, хайлшны үйлдвэрийн гол түүхий эд бөгөөд зарим төрлийн хүдрээс будаг гаргаж авдаг. Төмрийн хүдрийн ихээхэн нөөцтэй оронд АНУ, Канад, Энэтхэг, Франц, Швед, ӨАБНУ, Казахстан багтана. Мөн ОХУ, Украин, Бразил, Хятад, Австралид агуулга өндөртэй ордууд тогтоогджээ.

Дүгнэлт

- Нийгмийн байгаль орчинд үзүүлэх нөлөө нийгмийн хөгжлийн үе шатуудад янз бүр байжээ. Нийгмийн хөгжил газарзүйн орчинд явагдаж газарзүйн орчин хүний нийгэмд, хөгжил нь газарзүйн орчинд нөлөө үзүүлнэ. Иймээс нийгмийн амьдрал газарзүйн орчноос тусдаа оршин тогтнож чадахгүй билээ.
- Газарзүйн орчин бол нийгмийн хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Нийгмийн үйлдвэрлэлийн бүхий л салбарт гарсан дэвшил нь техник технологийн хөгжил бөгөөд хөдөлмөр хөнгөвчлөх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой автоматжуулалт юм.
- Орчин үед газрын нөөцийг зохистой ашиглах зорилгоор хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, усжуулах, намаг хатаах, хөрсний хүчиллэгийг бууруулах, эрдэс бордоо үйлдвэрлэх, таримал ургамлын генетик, селекцийг жолоодох зэрэг технологи нь байгалийн нөхцөлөөс маш бага хамаардаг болж байна. Байгалийн нөөцийг зохистой ашиглах, тогтвортой хөгжлийг дэмжих бодлого боловсруулах, экологийн асуудал зэрэг нь дэлхий нийтийг хамарсан асуудал болсоор байна.

Асуулт даалгавар

1. Байгалийн нөхцөл ба нөөцийн ялгааг тодорхойлж эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөг тайлбарлах
2. Ашигт малтмалын тархалтад тектоникийн хөдөлгөөнтэй холбоотой зүй тогтлыг жишээгээр тайлбарлах
3. Ашигт малтмал, хүдэр, эрдэс түүхий эд, орд газар, сав газар зэрэг нэр томъёог тайлбарлан жишээ гарган ярилцах
4. Нөхөн сэргээгдэх ба үл шавхагдах нөөцийн төсөөтэй ба ялгаатай талыг харьцуулан бичиж дүгнэлт хийх
5. Монгол улс нүүрсний нөөц их боловч гаднаас эрчим хүч импортоор авдаг шалтгааныг тайлбарлан бичээрэй
6. Дэлхийн байгалийн бүс бүслүүрийн зургийг ашиглан эрдэс түүхий эдийн нөөц ихтэй 2-3 улсыг харьцуулан эдийн засгийн газарзүйн тодорхойлолт бичээрэй.
7. Байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт нийгмийн хөгжилд ямар ямар үр дагавар үзүүлэх вэ?
8. Биологийн нөөцийн ач холбогдлыг дэлгэрүүлэн судалж ярилцлага, семинар хийх

Е.Батчулуун
Г.Уранчимэг

Зорилго

1. Үйлдвэрлэлийн салбарууд, ялгаа, орон зай-нутаг дэвсгэрийн хуваарилалтыг судлах;
2. Үйлдвэрлэлийн байршилд нөлөөлөх хүчин зүйлсэд үндэслэн нутаг дэвсгэрийн ялгарал, төрөлжилт үүсдэг шалтгааныг тайлбарлах;
3. Үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын бүтцийг нийгэм-эдийн засгийн хөгжил, өөрчлөлттэй холбон анализ хийж, жишээн дээр дүгнэлт гаргах;

Хураангуй

Байгалийн нөхцөл, нөөцийг ашиглан нийгмийн амьдралын хэрэгцээг хангахад чиглэсэн бүх үйл ажиллагаа нь үйлдвэрлэл юм. Мал өсгөж, тариалан эрхлэхээс бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэр, холбоо харилцаа, аялал жуулчлал зэрэг үйлдвэрлэлийн салбар (анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч) тус бүр нь байршил, ажиллах хүчний бүтэц, эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт зэргээрээ ялгагдах боловч хооронд нь салгах боломжгүй. Энэ бүлэгт үйлдвэрлэлийн газарзүйн онцлог, хамаарал, байршилд нөлөөлөх хүчин зүйлс болон ажиллах хүчний бүтцийн талаар дурдсан нь 8, 9, 10 дугаар бүлгийн агуулгыг судлахад суурь болно. Бүлгийн сүүлийн хэсэгт үйлдвэрлэлийн явцад үүсэж буй хөдөлмөрийн хуваарийн нутаг дэвсгэрийн буюу орон зайн ялгааны талаар дурдав.

Түлхүүр үгс: Үйлдвэрлэлийн анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч салбар, хөдөлмөрийн газарзүйн хуваарь

Keywords: Primary sector, Secondary sector, Tertiary sector, Quaternary sector, Spatial divisions of labour,

Е.Батчулуун (✉) Г.Уранчимэг



Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: batchuluun@msue.edu.mn; g_uranchimeg@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс

7.3 Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний бүтэц

Аливаа улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшинг тодорхойлохдоо голлож буй эдийн засгийн салбар, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний төрөл, эдгээр салбарт бүрт ажиллаж буй хүн амын эзлэх хувь, харьцаа зэргийг авч үздэг. Үйлдвэрлэлийн хэв шинж бүр ажиллагсдын тоо, мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн бүтээмж зэргээр ялгаатай бөгөөд үүнийг ажиллах хүчний бүтэц гэнэ. Уг салбарт ажиллагсдын тоо нь олборлох, боловсруулах үйлдвэрийн аль нь түлхүү хөгжсөнийг илэрхийлэх боловч хөдөлмөрийн бүтээмжийг бас тооцон үздэг. Тухайн улсын эдийн засгийн

идэвхтэй хүн амын зонхилох хэсэг үйлдвэрлэлийн ямар салбарт ажиллаж байгаа нь нийгмийн хөгжлийг илэрхийлэх нэг үзүүлэлт болно. Тухайлбал, хөгжингүй оронд үйлдвэрлэлийн анхдагч салбарт ажиллагсдын эзлэх хувь бага, эдийн засгийн идэвхтэй хүн амын зонхилох хэсэг гуравдагч, улмаар дөрөвдөгч салбарт ажилладаг бол буурай хөгжилтэй оронд хүн амын ихэнх хэсэг нь анхдагч салбарт ажиллана (Зураг 7.9). Учир нь нийгэм-эдийн засгийн хөгжил доогуур бол аж үйлдвэр хөгжөөгүй, улсын эдийн засгийг зөвхөн олборлох үйлдвэр ба мал аж ахуй, газар тариалангийн салбар бүрдүүлдэг, тэнд ажиллагсдын эзлэх хувь өндөр байдаг болно (Зураг 7.10).



Зураг 7.9 а) Өндөр хөгжилтэй ба буурай хөгжилтэй орнуудын ажиллах хүчний бүтцийн өөрчлөлт (1820-2020); б) Гурвалжин диаграммаар дүрслэх жишээ

Хөгжингүй ба хөгжиж буй орнуудын ажиллах хүчний бүтэц ялгаатай. Тухайн улсын нийгэм-эдийн засгийн хөгжил дээшлэх тутам үйлдвэрлэлийн анхдагч салбарт ажиллагсдын эзлэх хувь багасаж, гуравдагч, улмаар дөрөвдөгч салбар луу шилжинэ. Харин хөдөө аж ахуй ба олборлох салбарт (анхдагч) ажиллагсад их байвал нийгмийн хөгжил доогуур байгааг илтгэх үзүүлэлт болно. Жишээ нь: Их Британи улсад үйлдвэрлэлийн гуравдагч салбарт ажиллагчид 79 хувийг эзэлдэг бол энэ нь Балба улсад дөнгөж

16 хувь, Кени улсад 15 хувь байдаг ажээ (Зураг 7.11). Харин хөгжлийн хурдац сайтай, шинээр аж үйлдвэржсэн орон болох Малайз улсад нийт ажиллагсдын 45 орчим хувь нь гуравдагч салбарт ажиллаж байна. Хөгжингүй орон болох АНУ-д үйлдвэрлэлийн анхдагч салбарт ажиллагсад дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь энэ зургаас харагдаж байна. Эндээс үзвэл ажиллах хүчний бүтцийн ялгаа нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшинг илтгэнэ.

С.Хадбаатар

Зорилго

1. Анхдагч салбарын тархалт, байршилтад нөлөөлөх хүчин зүйлс, ерөнхий зүй тогтол, үйлдвэрлэлийн бусад салбартай холбогдох байдлыг судлах;
2. Мал аж ахуй, газар тариалан, эрдэс түүхий эдийн нөөц, тархалт, бүтээгдэхүүний төрөлжилтөд уур амьсгал, гадарга, геологийн тогтоц зэрэг физик газарзүйн хүчин зүйлсийн нөлөөг жишээгээр тайлбарлах;
3. Үйлдвэрлэлийн анхдагч салбарын онцлогийг бүс нутаг, улс орноор харьцуулан дүгнэлт гаргах;

Хураангуй

Үйлдвэрлэлийн анхдагч салбарт эрдэс түүхий эд, ашигт малтмал олборлох, уур амьсгал, газар, усны нөөцийг ашиглах болон ХАА-н үйлдвэрлэлийн салбарууд багтана. Энэ салбарын үйлдвэрлэл нь боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн гаргадаг хоёрдогч үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах ба аль ч улсад, аж ахуй, эдийн засгийн суурь болдог онцлогтой. Энэ бүлэгт ашигт малтмалын тархалтыг дагасан уул уурхайн олборлолт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрөлжилт, хэмжээ, онцлог зэргийг бүс нутгаар болон голлох улс орны хэмжээнд холбогдох эх сурвалжид тулгуурлан нэгтгэсэн болно.

Түлхүүр үгс: Анхдагч салбар, хөдөө аж ахуй, газар тариалан, мал аж ахуй, ургамлын аж ахуй, орд газар, олборлох үйлдвэр

Keywords: Primary industry, Agriculture, Farming, Livestock industry, Crop production, Mining

С.Хадбаатар (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим

e-mail: khadbaatar@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс

Хүснэгт 8.1 Загас агнуурын хэмжээ (Эх сурвалж: The state of world fishers and aquaculture, FAO, 2020)

№	Газарзүйн бүслүүр	Загас агнуур (жил бүрийн дунджаар, сая.тн.)							Эзлэх хувь
		1980	1990	2000	2015	2016	2017	2018	
1	Он								
2	Тропикийн	13.01	18.14	22.05	25.20	25.98	26.55	27.31	32
3	Экваторын (Эль-нино)	17.37	21.45	20.21	15.49	14.53	16.03	19.07	23
4	Арктик ба Антарктик	0.48	0.19	0.14	0.24	0.28	0.26	0.33	0
5	Нийт	72.10	81.86	81.56	80.51	78.27	81.21	84.41	100

зэрлэг ургамал бөгөөд тэдгээрийг тарималжуулах хэлбэр юм. Гэвч генетик-селекцийн хөгжил энэ асуудлыг бүрэн шийдээгүй байна.

Ази, Европ, Америкийн хойд хэсгийн хүйтэн, сэрүүн уур амьсгалтай нутгаас гаралтай таримал ургамал бараг байхгүй байхад халуун дулаан уур амьсгалтай, уулархаг нутгаас гаралтай ургамал олон. Уулын босоо бүслүүр нь ургамлын төрөл, зүйл үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг ба ихэнх таримал ургамлын эх нутаг нь дулаан уур амьсгалтай уулархаг нутаг байжээ.

Газарзүйн их нээлтээс хойш таримал ургамлын төрөлд эрс өөрчлөлт гарсан нь нэг талаас далай тэнгисийн ба төмөр замын тээврийн хөгжил, нөгөө талаас шинжлэх ухааны (ургамал судлал, агротехникийн) ололт амжилт болон атар газар эзэмших болсонтой холбоотой.

Ийм учраас таримал ургамлын байршилт жигд биш, нэг улс, тив дээр таримал ургамлын зүйл бөөгнөрсөн байхад зарим газар цөөн, огт байхгүй ч тохиолдол байна. Ази, Европт таримал ургамлын төрөл, зүйл харьцангуй их. Таримал ургамлын тархалт дээр үндэслэн тэдгээрийн анх үүссэн голомт нутгийг Н.И.Вавилов 1939 онд дараах байдлаар ялгасан нь одоог хүртэл хэрэглэгдэж байна. Үүнд:

1. *Баруун-Өмнөд Ази*: Энэтхэг, Афганистан, Дундад Ази, Бага Ази, Кавказын уулархаг орны улсууд багтана. Энд зөөлөн буудай, хөх тариа, вандуйн зарим зүйл, азийн хөвөн, тутарга, зарим зүйл олс, шар лууван, сармис, өргөст хэмх, бууцай, усан үзэм зэрэг олон ургамлыг тарималжуулжээ.
2. *Зүүн-Өмнөд Ази*: Энэтхэг-Хятадын ба Малаккийн хойг, Солонгос, Япон зэрэг орнууд багтана. Эндээс хошуу будаа, арвай, шар буурцаг, сагаг, улаан манжин, сонгино, цай, ялмын мод, амтаг гуа, зарим зүйл чихрийн нишингэ, олс, жүрж зэрэг ургамлууд үүсчээ.
3. *Газар дундын тэнгисийн бүс*: Хойд-Африк, Грек, Итали, Испани, Арабын хойг, Бага Азийн хойгийн баруун эргийн нутгууд хамрагдана. Эндээс хатуу буудай, хэд хэдэн зүйл хошуу будаа, том үрт маалинга, чихрийн манжин, байцаа, чидун жимс (тосны) зэрэг таримлууд бий болжээ.
4. *Абиссиний*: Зүүн хойд Африк, Этиопийн уулархаг нутаг багтана. Энэ нь зарим зүйл арвай, буудай, буурцгийн хэд хэдэн зүйл, хошуу будаа, кофений мод зэрэг таримал ургамлын эх нутаг болно.
5. *Мексик-Перугийн*: Төв ба Өмнөд

Х.Цогбадрал

Зорилго

1. Үйлдвэрлэлийн хоёрдогч салбарын онцлог ба орон зайн ялгааг газарзүйн хүчин зүйлстэй холбон тодорхойлох;
2. Бүс нутгийн эдийн засагт аж үйлдвэр хэрхэн нөлөөтэй болохыг хөгжингүй буй хөгжиж буй орнуудын жишээн дээр тайлбарлах;
3. Байгаль-нийгэмд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөг техник технологийн хөгжилтэй холбон баримтад тулгуурлан авч үзэх;

Хураангуй

Аж үйлдвэрийн газарзүй нь үйлдвэрлэлийн салбаруудын байршил, тархалт, нөлөөлөх хүчин зүйлсийг орон зайн хүрээнд авч үздэг. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг нэг шалгуур нь аж үйлдвэр юм. Өндөр хөгжилтэй орнуудад боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбар өндөр хөгжсөн байдаг бол хөгжиж буй орнуудад олборлох, түүхий эд бэлтгэх салбар зонхилдог. Шинжлэх ухаан, технологийн өнөө үед аж үйлдвэрийн болон ажиллах хүчний бүтцэд гарч буй өөрчлөлт нь бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд ихээхэн нөлөөлж аж ахуйн шинэ төвүүд үүсэх, төрөлжилтийн шинэ хэлбэр бий болоход хүргэснээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлд орон зайн болон хөгжлийн ялгаа багасах, өртөг хэмнэх боломжтой болж байна. Энэ бүлэгт үйлдвэрлэлийн хоёрдогч хэв шинж болох аж үйлдвэрийн газарзүйн онцлог, орон зайн байршил, нөлөөлөх хүчин зүйлс ба бүс нутгийн ялгааг багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт тулгуурлан авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Аж үйлдвэр, түлш эрчим хүчний үйлдвэр, техник-технологи, ажиллах хүчний бүтэц, дэд бүтэц

Keywords: Manufacturing, Fuel and energy industry, Technology, Labor force structure, Infrastructure

Х.Цогбадрал (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: tsogbadra@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс

Ашигт малтмалын ихээхэн нөөцтэй АНУ, Канад, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнуудад түүхий эд олборлох үйлдвэрлэл өндөр хөгжсөн хэдий ч нийт дүнгээр хөгжингүй орнуудын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд 2 хувь, хөгжиж буй орнуудад 14 хувийг эзэлж байна (<http://www.perspektivy.info/rus/>).

АНУ, Япон, Баруун Европын орнууд эрдэс, түүхий эдийн хэрэглээнийхээ 1/3 хувийг хөгжиж буй орнуудаас, бусад хэсгийг дотоодоосоо болон Канад, Австрали, ӨАБНУ хөгжингүй улсуудаас хангаж байна. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарьт уул уурхайн олборлолтоор АНУ, Канад, Австрали, ӨАБНУ, Бразил, Энэтхэг, Хятад, ОХУ зэрэг 8 улс голлож байна. Байгалийн хийг шингэрүүлэн боловсруулах технологи Нигер, Алжир, Индонез зэрэг улсад өндөр хөгжиж экспортын ашиг нь ихээхэн нэмэгдэж байна.

Хүснэгт 9.1 Түлшний ашигт малтмал олборлолтоор голлох орнууд

№	Газрын тос	Байгалийн хий	Нүүрс
1	Саудын Араб	ОХУ	Хятад
2	АНУ	АНУ	АНУ
3	ОХУ	Канад	Энэтхэг
4	Иран	Их Британи	Австрали
5	Мексик	Алжир	ОХУ
6	Венесуэл	Индонез	Герман
7	Хятад	Голланд	ӨАБНУ
8	Норвег	Иран	Польш
9	Их Британи	Узбекистан	Украин
10	Ирак	ӨАБНУ	Казахстан

(Эх сурвалж: <https://yearbook.enerdata.net/total-energy/world-consumption.htm>)

2010 оноос хойш зэсийн олборлолт буурсан нь томоохон ордуудын хүдрийн агуулга буурсан, Чили, Перуд нийгмийн асуудал (ажил хаялт) зэрэг хүчин зүйлс, хөнгөнцагааны эрэлт нэмэгдэхэд

Австралид шинэ орд нээж олборлолт нэмэгдсэн зэрэг нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэд нийгэм-эдийн засгийн шалтгаан ихээр нөлөөлдгийн жишээ юм. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ жилд 5 орчим хувиар өсч байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтөөс өндөр, хөгжиж буй орнуудыхаас доогуур байгаа нь олон улсын зах зээлд эрэлт өсөх нөхцөл болж байна.

9.2.2 Газрын тосны үйлдвэр

Газрын тос боловсруулах нь стратегийн өндөр ач холбогдолтой үйлдвэрлэл бөгөөд ашиг орлого өндөртэй салбар тул нөөц бүхий орнуудын эдийн засагт ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Ялангуяа шинээр аж үйлдвэржиж байгаа болон хөгжиж буй хямд ажиллах хөдөлмөрийн нөөц ихтэй Ази, Африкийн орнуудад гадаадын хөрөнгө оруулалт ихээр нэвтэрч олборлолт болон үйлдвэрлэлийн хэмжээ эрс өсчээ. Техник технологийн хөгжилтэй уялдан эх газрын нөөцөөс гадна далай, тэнгисийн эргээс 1,000 хүртэл метр (шельф)-г 600 хүртэл метрийн гүнээс газрын тос олборлож байна. Газрын тосны судлагдсан нөөцийн нийт хэмжээ 200 орчим тэрбум тонн байгаагаас ихэнх нь *Баруун Өмнөд Ази* (Арабын хойг); *ОХУ* (Баруун Сибирь, Обь мөрний дунд ба адаг орчим); *Төв болон хойд Африк* (Алжир, Нигер, Ливи); *Хойд Америк*; *Латин Америк* (Мексик, Венесуэл, Перу); *Зүүн Өмнөд Ази* зэрэг бүс нутагт ногдоно (Дэлгэрэнгүйг “Байгалийн нөөцийн газарзүй” бүлгээс үзнэ үү).

ОПЕК-ийн орнууд. Дэлхийн 90 оронд газрын тос олборлодог боловч 90 хувь нь 10 улсад л ногдоно. Дэлхийн хэмжээгээр жилд 3.6 тэрбум тонн газрын тос экспортлодгийн 60 хувь нь хөгжиж буй орнууд, түүний дотор

Ц.Сэр-Од

Зорилго

1. Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын эдийн засгийн бүтцэд эзлэх байр суурийг тодорхойлох, статистик үзүүлэлтийг бүс нутгаар харьцуулах;
2. Тээврийн сүлжээний хөгжил, нөлөөлж буй байгаль-нийгмийн хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэх, үйлчилгээний салбарын хөгжилд тээврийн системийн гүйцэтгэх үүргийг тайлбарлах;
3. Олон улсын худалдаа, банк, санхүүгийн үйл ажиллагааны онцлогийг судлах;

Хураангуй

Үйлдвэрлэлийн гуравдагч салбарын хөгжил нь үйлчилгээний болон тээврийн салбарын өрсөлдөх чадвараар тодорхойлогддог бөгөөд анхдагч болон хоёрдогч салбарын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээ юм. Харин дөрөвдөгч салбарын үйлдвэрлэл нь бусад салбарын үйлдвэрлэл, технологийн дэвшил, хоорондын хамаарал, менежмент зэргийг судалгаа, шинжилгээний аргаар боловсруулж хэрэгжүүлэх үйл явц буюу мэдлэгийн эдийн засгийн салбар юм. Энэ бүлгийн эхний хэсэгт үйлдвэрлэлийн гуравдагч салбарыг төлөөлүүлж аялал жуулчлал, тээвэр, харилцаа холбоо, худалдаа, банк, санхүүгийн үйлчилгээний түүх, хөгжлийн өнөөгийн түвшин, түүнд нөлөөлсөн нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг тоймлон дурьдсан. Сүүлийн хэсэгт үйлдвэрлэлийн дөрөвдөгч салбар болох аутсорсингийн үйлчилгээ, реэкспорт, зах зээл судлалын талаарх онолын ойлголт, дэлхийн хөгжлийн чиг хандлага болон улс орон, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлж буй нөлөөг холбогдох тоо баримтад тулгуурлан нэгтгэн оруулсан болно.

Түлхүүр үгс: Тээврийн сүлжээ, Үйлчилгээний төрөл, Холбоо харилцаа, Аялал жуулчлал, Экологийн аялал жуулчлал

Keywords: Transportation system, Service types, Communication, Tourism, Ecotourism

Ц.Сэр-Од (✉)

Монгол улсын боловсролын их сургууль, Газарзүйн тэнхим
e-mail: serod@msue.edu.mn

©Батчулуун, Е., Цогбадрал, Х. (Ред.). (2021). Нийгэм-эдийн засгийн газарзүйн үндэс


төв удирдлага байрладаг. Цахиурын хөндийн төв San Jose, зэргэлдээх Mountain View, Palo Alto, Santa Clara, Sunny vale, Cupertino зэрэг жижиг хотод мэдээлэл харилцааны технологи, компьютер, программ хангамж, электрон техникийн Google, Facebook, Microsoft (1975), Yahoo (1995), Oracle (1977), программ хангамжийн Adobe Systems (1982), процессор болон компьютерийн эд анги, технологи үйлдвэрлэдэг ADM (Advanced Micro Devices, 1969), Intel (1968), Hewlett-Packard буюу HP, ухаалаг утас үйлдвэрлэлийн Apple Inc (1976), онлайн ба дуудлага худалдааны eBay (1995), компьютер сүлжээний Cisco Systems (1984), антивирус, компьютерийн хамгаалалтын программ үйлдвэрлэдэг McAfee (1989) зэрэг олон компани үйл ажиллагаа явуулдаг⁵.

⁵ Eric, Weiner. (2016). The Geography of Genius: A Search for the World's Most Creative Places from Ancient Athens to Silicon Valley. ISBN: 9781451691658, Simon Schuster Published. 368 pp.

Харилцаа холбооны нэг чухал хэрэгсэл бол гар утас бөгөөд 2020 онд дэлхий даяар үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 6.95 тэрбум байсан бол 2021 он гэхэд 7.1 тэрбум, 2024 онд 7.41 тэрбумд хүрнэ хэмээн тооцоолсон байна⁶. Гар утас хэрэглэгчдийн тоо ийнхүү тасралтгүй өсөж байгаа нь технологийн үсрэнгүй хөгжил болон хэрэглээний хялбар шийдэлтэй холбоотой хэдий ч дэлхийн бүс нутаг, улс орнуудад энэ үзүүлэлт харилцан адилгүй (Зураг 10.25).

Сансрын холбоо. Энэ систем нь дэлхийг тодорхой радиус бүхий тойрог замаар тойрч байгаа хиймэл дагуулаар дамжуулан газрын станц хоорондын дохио дамжуулах зарчимд үндэслэгдэн анх зохиогдсон. Хиймэл дагуул нь газрын станцаас радио долгионыг хүлээн авч буцаан дамжуулах үүрэг гүйцэтгэдэг.

⁶ Data.worldbank.org/products/#mobile



Зураг 10.25 1,000 хүнд ногдох автомашин, гар утас, компьютерээр тэргүүлэгч орнууд (Эх сурвалж: Diercke International Atlas, 2020)

Хүснэгт 10.12 Дэлхийн шилдэг 10 банк (Эх сурвалж: <https://www.investopedia.com/>, 2019)

№	Банк	Нийт орлого (тэрбум ам.дол)	Ашиг (тэрбум ам.дол)	Зах зээлийн үнэлгээ (тэрбум ам.дол)	Хувьцааны өгөөж (%)	Хувьцааны арилжаа
1	Industrial and Commercial Bank of China (IDCBY)	123.6	45.3	231.8	6.9	OTC
2	JPMorgan Chase and Co (JPM)	114.6	36.4	280.1	5.8	New York
3	Japan Post Holdings (JPHLF)	112.3	4.7	34.4	28.3	OTC
4	China Construction Bank (CICBY)	102.2	38.7	196.6	3.7	OTC
5	Bank of America (BAC)	91.2	27.4	188.5	18.2	New York
6	Agricultural Bank of China (ACGBY)	89.7	30.9	131.5	14.1	OTC
7	Credit Agricole SA (CRARY)	83.4	5.4	22.3	32.4	OTC
8	Wells Fargo and Co (WFC)	82	19.6	123.8	35.4	New York
9	Bank of China (BACHF)	79.4	27.2	109.1	12.7	OTC
10	Citigroup Inc (C)	74.3	19.4	91.9	25.9	New York

Хүснэгт 10.13 Дэлхийн улс орнуудын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, 2016 (Эх сурвалж: <https://tradingeconomics.com/stocks>)

№	Улсын нэр	Компани
1	Энэтхэг	5,191
2	АНУ	4,102
3	Канад	3,876
4	Япон	3,470
5	Испани	3,167
6	Хятад	2,494
7	Их Британи	2,179
8	Австрали	1,959
9	БНСУ	1,767
10	Хонконг	1,459

Нью-Йоркийн хөрөнгийн бирж.

Хувьцаа байрлуулах хамгийн нэр хүндтэй газар бол Нью-Йоркийн хөрөнгийн бирж юм. Хүмүүс эхний үед гудамжинд арилжаа хийдэг байснаа 1790-ээд оны үеэс *Wall Street* гудамжинд амралтын өдрүүдэд байнга цугладаг болжээ. Эндээс Америк дахь хөрөнгийн зах зээлийн үүсэл эхэлсэн гэж үздэг. Тухайн үед уг гудамжинд хувьцааны дуудлага худалдаа болж, зарим өдөр 100 хүртэлх хувьцаа арилжиж байжээ. 1792 онд Нью-Йоркийн хөрөнгийн бирж байгуулагдсанаас хойш

200 гаруй жил өнгөрч Wall Street Америк төдийгүй дэлхийн санхүүгийн ертөнцийн нэрийн хуудас болсон байна. 24 брокертэй энгийн зах зээлээс 1,500 гаруй гишүүнтэй нийгэмлэг болтлоо өргөжин тэлсэн Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр одоо дэлхийн өнцөг булан бүрийн 2,000 гаруй томоохон компанийн хувьцаа худалдагдаж байна. Энд АНУ-ын болон гадаадын компаниудыг бүртгэж, бонд, хувьцаа болон бусад үнэт цаас, хөрөнгө оруулалтын арилжаа хийдэг.

Хөрөнгийн биржүүдийн жагсаалтад нэгдүгээр байранд ордог энэ бирж дээр гарахын тулд компаниуд маш нарийн сонгон шалгаруулалтыг давах шаардлагатай байдаг. Хувьцаагаа арилжаалахын тулд энэ тэргүүнд 2,000-аас доошгүй хувьцаа эзэмшигчтэй байхын дээр 500 сая доллараас доошгүй бэлэн мөнгөний эргэлттэй, жилийн тайлан тэнцлээ олон нийтэд мэдээлж байх үүргийг хүлээнэ.

Зах зээлийн үнэлгээний хувьд хамгийн өндөр шаардлагыг энэ бирж тавьдаг. Харин ажилласан хугацааны хувьд олон жил шаардахгүй, 12 сараас доошгүй хугацаанд үйл ажиллагаа хэвийн явуулсан байхад боломжтой.

Е.Батчулуун
С.Хадбаатар

Зорилго

1. Байгаль нийгмийн тулгамдаж буй асуудлууд, нөлөөлж буй хүчин зүйлс, гарч буй үр дагаврын орон зайн ялгааг судлах;
2. Нийгмийн хөгжлийн түвшинтэй холбон жишээгээр тайлбарлах;
3. Тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд газарзүйн үүднээс хандах арга барилд суралцах;

Хураангуй

Орчин үед газарзүйн шинжлэх ухаан байгаль орчин судлалын чиглэлээр хөгжиж байна. Байгаль-нийгмийн тулгамдсан асуудлууд болох уур амьсгалын өөрчлөлт, хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол, цэвэр усны хүрэлцээ, биологийн төрөл зүйлийн хомсдол, хоол хүнсний аюулгүй байдал, ядуурал, өлсгөлөн, халдварт өвчний тархалт зэргийн орон зайн учир шалтгааныг газарзүйн үүднээс судлах нь тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх боломж юм. Энэ бүлэгт зарим асуудлыг сонгон авч улс орон ба бүс нутгийн нийгмийн хөгжлийн түвшин нь нөөцийн хэрэглээ ба хомсдолд хэрхэн нөлөөлдөг талаар дурдсан болно.

Түлхүүр үгс: Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, усны хомсдол, ядуурал, өлсгөлөн, экологийн мөр

Keywords: Environmental degradation, Climate change, Water scarcity, Poverty, Ecological footprint

шалтгаалж байна. Жишээ нь: Дэлхийн хуурай газрын нийт талбайн гуравны нэгээс илүү, цэвэр усны нөөцийн 75 хувь нь газар тариалан, мал аж ахуйд ашигладаг, газрын доройтлын улмаас нийт газар нутгийн 23 хувь нь хөдөө аж ахуйн бүтээмж буурсан, 1870-аад оноос хойш шүрэн арлын амьд биетийн тэн хагас нь устсан гэх мэтийг дурьдаж болно. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэж байгаа байгалийн гамшигт үзэгдлүүд, далайн түвшний өсөлтийн улмаас биологийн төрөл зүйл устаж байна. Тропикийн чийглэг ой хамгийн баян биологийн төрөл зүйлтэй бөгөөд дэлхийн нийт ойн талбайн 8 хувийг эзэлдэг. Амазонкийн

нам газар нь дэлхийд талбайгаар хамгийн томд орох нам газар төдийгүй халуун орны чийглэг мөнх ногоон ойн талбайгаар ч хамгийн том нь юм. 6,000 км² талбай эзлэх ой нь Өмнөд Америкийн гадаргын 50 хувь юм. Биологийн төрөл зүйлээр хамгийн баялаг энэ ойд 1,800 зүйлийн шувуу, 250 төрлийн хөхтөн бий. WWF ба Лондонгийн Амьтан судлалын нийгэмлэгийн (ZSL) тайлангаас үзвэл зэрлэг амьтдын популяци 1970-2016 оны хооронд 68 хувиар цөөрч Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудын зэрлэг амьтдын тоо толгой ихээхэн багасжээ. Хүнсний үйлдвэрлэл бол биологийн төрөл зүйл устах хамгийн гол хүчин зүйл болно.

Дүгнэлт

- Нийгмийн хөгжлийг байгалиас, байгалийн нөхцөл нөөцийг нийгмээс салгах аргагүй. Ашигтай байрлал, эрдсийн нөөц, ой ургамал, усан хангамж зэрэг байгалийн хишиг нь нийгмийн хөгжилд сайнаар нөлөөлөх боловч хэт их ашиглалт, үр ашиг муутай зарцуулалт нь байгаль орчны доройтолд хүргэнэ.
- Агаар, усны бохирдол, хөрс, газар, бэлчээрийн доройтол үүсэх болсон үндсэн шалтгаан хүний үйл ажиллагаа, “хэтэрсэн” ашиглалт юм. Иймд ашиглалт ба нөхөн сэргээлт, үйлдвэрлэл ба хэрэглээний зохицлыг тохируулж тааруулах аваас нийгмийн хөгжил “тогтвортой” байх болно. Нэг үгээр хэлбэл, хэт шунахгүйгээр, хэрэгцээндээ тохируулан, үр ашигтайгаар хэрэглэж, хойч үедээ “үлдээж”, ухаалаг хандсан үйлдэл бол тогтвортой хөгжил юм.
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн өлсгөлөн, ядуурал, уур амьсгалын өөрчлөлт, ус болон биологийн төрөл зүйлийн хомсдол зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд газарзүйн ойлголт мэдлэг, сэтгэлгээ чухал болно.

Асуулт даалгавар

1. Байгаль-нийгмийн тулгамдсан асуудлаас сонгон авч хамаарлын зураглал үйлдэн учир шалтгааныг тайлбарлаж бичээрэй.
2. Уур амьсгалын өөрчлөлт хөдөө аж ахуй, мал аж ахуйд ямар нөлөө үзүүлж байгаа вэ? Орон нутгийн жишээн дээр үндэслэн жишээ, баримттайгаар дүгнэлт гаргаж бичээрэй.
3. Экологийн мөр гэж юу вэ? Энэ нь улс орны хөгжлийн түвшнээс хэрхэн хамаарах вэ? “Хөгжлийн газарзүй” бүлэгт дурдсан нийгэм-эдийн засгийн түвшний ялгаанд үндэслэн шалтгааныг тайлбарлаарай.

НЭРИЙН ХЭЛХЭЭ

- Абуко 330
 Австронез хэлний аймаг 132
 Авто замын тээвэр 335, 336, 337
 Автомашин 332, 334, 337, 348, 350, 351
 Агаар, сансрын арга 20
 Агаараас авсан гэрэл зураг 9, 10, 20, 21
 Агаарын бохирдол 332
 Агаарын тээвэр 331, 332, 335, 336,
 Агломераци 26,
 Адууны аж ахуй 251
 Аж ахуй 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 23, 27
 Аж ахуйн систем 288
 Аж үйлдвэр 216, 217, 218, 224, 225, 227, 228, 229, 323, 324
 Аж үйлдвэрийн байршил 224, 287, 288
 Аж үйлдвэрийн бүс 287
 Ажиллах хүчний бүтэц 283, 286, 287, 319
 Ажил эрхлэлт 80
 Аз жаргалын индекс 62
 Ази, Номхон далай 324
 “Азийн бар” улсууд 69
 Азийн хөгжлийн банк 239
 Азорын их даралт 326
 Аквакультура 252, 253
 Албан хэл 136, 137, 139
 Америк 322, 334, 338, 342, 345, 350
 Америк хэл 133, 135
 Амьдралын түвшин 58
 Амьдралын стандарт 61
 Англи хэл 131, 132, 134, 136, 137, 138
 Антропogeограф 2
 Анхдагч хэв шинж 217, 218, 219, 225, 227, 241, 271
 Аозу зурвас 34
 Арвай 255, 256, 260
 Ареалын арга 16
 АСЕАН 232, 238, 240, 241
 Аутсорсинг 321, 353, 354, 355
 Африк 328, 329, 339, 343
 Африкийн жилүүд 42
 Ачаа эргэлт 334, 335, 336, 340, 341, 342, 344
 Ашигт малтмалын нөөц 297, 300
 Аялагч 329
 Аялал жуулчлал 321, 324, 326, 327
 Баганан диаграмм 17
 Байгалийн нөөц 4, 5, 6, 12, 26
 Байгалийн нөхцөл 1, 3, 27
 Байгалийн хий 272, 277, 277, 279
 Байгалийн хийн үйлдвэр 294, 295
 Байгаль нуур 342
 Байршил тодорхойлох хиймэл дагуулын систем 22, 25
 Байршилд нөлөөлөх хүчин зүйл 215, 218, 219, 220, 222, 223,
 224, 241
 Байршлын онол 222, 223, 224
 Банк 326, 349, 350, 351, 352, 356,
 Банту хэл 134
 Баялгийн хуваарилалт 72, 73, 77
 Бенидорм 326, 327
 Берингийн хоолой 342
 Благовещенск 342
 Боловсролын түвшин 61
 Боловсруулах үйлдвэр 221, 225, 228, 230, 241
 Болонг 333
 Боомт хот 343, 344
 Брикама 333
 Буддын шашны тархалт 147
 Бүгд найрамдах засаглал 35
 Бүс нутаг 2, 3, 4, 5, 6, 7, 17, 24, 25, 27
 Бүтээгдэхүүний жин 222
 Бүтээгдэхүүний өртөг 219, 221
 Бюргесийн “нэг төвт тойргон бүс загвар” 12
 Важраяна урсгал 145
 Веберийн онол 222, 223, 224
 Гаалийн холбоо 332
 Гадаад худалдаа 232, 235, 236, 330, 349
 Гадаад худалдааны эргэлт 235, 236
 Газар ашиглалт 3, 8, 9, 10, 20, 22, 26, 27, 203
 Газар доорх ус 327, 328
 Газар дундын тэнгис 326, 327, 342, 357
 Газар тариалан 243, 244, 255, 256, 280
 Газарзүйн байрлал 327, 329, 330
 Газарзүйн мэдээллийн систем 12, 24
 Газарзүйн судалгаа 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 13, 27
 Газрын доройтол 331
 Газрын түвшний гэрэл зураг 20
 Гамби 326, 328, 329, 330, 331, 333
 Гар утас 347, 348, 351
 Гахайн аж ахуй 252
 Геометрийн хил 32
 Гео–мэдээллийн арга 12
 Гео–орон зайн технологи 13, 22
 Геотермаль станц 303, 304
 Геотехник 2
 Герман 326, 328, 336, 338, 339, 340, 342, 350
 Гол мөрний тээвэр 345,
 Гуравдагч хэв шинж 217, 218, 225
 Гурвалжин диаграмм 18
 Гэрээт ажил 354, 355
 Далайд гарцгүй улс 48
 Далайд гарцтай улс 48
 Далайн орнууд 36
 Далайн тээвэр 343, 344
 Далайн чанадах нутаг 31
 70–ын дүрэм 87
 Дамжуулах хоолой 336, 340, 341, 342
 “Дарсны хундага” хэлбэртэй диаграмм 73

- Даяаршил 2, 5
Дотоодын нийт бүтээгдэхүүн 323, 233
Дөрөвдөгч хэв шинж 216, 218, 225, 227
Дружба–1, 2 341
Дундад зууны үе 40
Дуу чимээний бохирдол 332
Дэд бүтэц 283, 288, 289, 290, 291
Дэлхийн банк 239
Дэлхийн дотоод гүний дулаан 302, 304
Дэлхийн худалдааны байгууллага 239
Европ 322, 324, 327, 329, 330, 334, 338, 339, 341, 350
Европжуу төрхтөн 151
Европын холбоо 239, 240
Ердийн өсөлт 84
Жонсоны “Стандарт дүрэм” 138
Жуулчид 327, 328, 329, 330, 333
Загас агнуур 244, 252, 254, 255
Зайнаас тандах судлал 22
Зар сурталчилгаа 238
Засаг захиргааны зарчим буюу долоогийн дүрэм 10
Засаглалын хэлбэр 35
Зах зээл 216, 219, 221, 222, 223, 227, 229, 230, 231, 232, 238, 241, 285, 287, 288, 292, 293, 307, 310, 314, 316, 317, 319
Зах зээл судлал 321, 353, 356
Захын дүүргийн хотжилт 25
Зорчигч эргэлт 335, 338, 339, 340, 346
Зөв бус хэлбэрт загвар 9
Зурагзүйн дүрслэлийн аргууд 13, 15
Ижил шугамын арга 16
Импорт 220, 221, 228, 231, 234, 236, 241, 349, 350
Интернэт 326, 347, 349, 350, 353, 355,
Исламын ертөнц 145
Исламын шашны тархалт 146
Испани 326, 327, 328, 337, 338, 339, 352, 357
Испани хэлний тархалт 132, 139
Иудейн шашин 140
Их хотын бүс 17, 23
Картограммын арга 16
Картодиаграммын арга 16
Каспи 342
Каучук 264, 266, 267, 271
Качикалли 330
Килийн суваг 344,
Ковыктагийн хийн орд 342
Колончлолын оргил үе 40
Колоний системийн задрал 42
Кондратьевийн долгион 285
Конурбацц 25
Күнз, Дао, Синтогийн шашин 140
Ладог 344
Латин хэл 132
Либер 343
Мал аж ахуй 243, 244, 245, 246, 252, 256, 260, 261, 280
Мальтусын онол 91
Маркетинг 314, 315
Маркетингийн зарчим буюу гурвын дүрэм 9
Материалын индекс 222
Махаяна урсгал 145
Машины үйлдвэр 289, 305, 308, 309, 311
Мегалополис 15, 26
Мекка хот 145
Метрополис хот 26
Мод боловсруулах үйлдвэр 317, 318
Мод бэлтгэл 244, 271, 272
Монгол төрхтөн 149
Мэдээллийн технологи 4, 5, 216, 227, 229, 347, 353, 354, 357
Навчин хэлбэрт төлөвлөлт 9
Нано технологи 353,
Наран шарлага 326, 327, 329,
Нарны энерги 302
Негржүү төрхтөн 148, 149
Нефтийн бүтээгдэхүүн 324, 342, 356
Нефть 340
Нигер–Конго хэлний язгуур 130
Нийгмийн сүлжээ 347
Нийгмийн хөгжил 27
Нийгэм–эдийн засгийн газарзүй 1, 2, 4, 5, 6, 27
Нисгэгчгүй автомат төхөөрөмж 23
НҮБ–ын албан ёсны хэл 138
Нүүрсний үйлдвэр 295
Нью–Йоркийн бирж 350
Нэгдмэл улс 38
НЭЗ–ийн газарзүйн судалгааны арга 4
НЭЗ–ийн газарзүйн судлагдахуун 4, 5
Нэхмэлийн үйлдвэр 294, 313, 314
Нээлттэй тэнгис 33
Нярайн эндэгдэл 61
Овьёс 260
Ойн аж ахуй 271, 319
Ойн нөөц 316, 317
Ойрх Дорнод 325
Олборлох үйлдвэр 225
Олон улсын аялал жуулчлал 324, 325
Олон улсын валютын сан 239
Олон улсын санхүү, зээлийн харилцаа 232
Олон улсын харилцаа 231, 232, 241
Олон улсын худалдаа 234
Олон улсын эдийн засгийн харилцаа 231, 232, 235
Онгон зэрлэг байгаль 330
Онег 344
ОПЕК–ийн орнууд 292, 293, 294
Оптикын тандан судалгаа 23
Оюун санааны дэд систем 126
Өнгөт дэвсгэрийн арга 16
Өнгөт металлын 272, 273
Панамын суваг 344
Плантацийн аж ахуй 268
Протестант урсгал 142, 144, 145, 151

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Агаарын бохирдол (Air pollution). Байгалийн ба хүний үйл ажиллагааны нөлөөгөөр агаарын хий ба аэрозолууд амьд организмын амьдралд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрэх үзэгдэл

Агаарын гэрэл зураг (Aerial photo, aerophoto). Нисэх онгоц болон агаарын бусад нисэх аппаратын тусламжтай гарган авсан дэлхийн гадаргын фотографийн хавтгай дүрслэл

Агломераци (Agglomeration). Хотуудын тэлэлтийн үр дүнд зэргэлдээх хотууд хэмжээний хувьд томорч хоорондоо нийлэх үзэгдэл

Аж үйлдвэрийн хувьсгал (Industrial revolution). Үйлдвэрийн технологи болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлд цоо шинэ өөрчлөлт гарсан үе

Ажилгүйдэл (Unemployment). Хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давах үзэгдэл

Ажиллах хүч (Labor force). Ажиллах хүчний нийт тоо

Ажиллах хүчний бүтэц (Structure of labor force). Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо, мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн бүтээмж зэргийн ялгаа

Ажиллах хүчний шилжилт (Labour migration). Хүмүүс ажлын байр чөлөөтэй хайх, амьдралын нөхцөлөө сайжруулахын тулд гадагшаа шилжих үйл явц

Аз жаргалын индекс (Happy planet index). Хүмүүс амьдралдаа сэтгэл хангалуун байгаа байдал, дундаж наслалт ба байгаль орчны нөлөөг хамтатган авч үзсэн үзүүлэлт

Албадлагын шилжилт (Forced migration). Байгаль орчин, эдийн засаг, нийгэм, улс төрийн зэрэг гадаад хүчин зүйлийн улмаас өөрийн хүслээр бус үүсэж буй хүн амын шилжих хөдөлгөөн

Антропоген хүчин (Anthropogenic factor). Байгалийн нөөцийг ашиглаж, нөхцлийг өөрчилж буй хүний үйл ажиллагааг илэрхийлсэн ойлголт

Антропосфер (Anthroposphere). Биосферийн хөгжилд

нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл

Ареалын арга (Method of area). Юмс, үзэгдлийн тархацын талбай, байрлалыг зураас, өнгө, тэмдэг, үсэг ба индексийн тусламжтайгаар үзүүлэх арга

Арифметик нягтшил (Arithmetic density). Тухайн улсын хүн ам ба газар нутгийн харьцаа

Аутсорсинг (Outsourcing). Ажлын тодорхой хэсгийг эсвэл бүтнээр нь бусдаар хийлгэх хэлбэр

Ачаа эргэлт (Freight turnover). Тээврийн хэрэгслийн тээвэрлэсэн ачааны хэмжээ болон зайн үржвэр. Ачаа эргэлтийг тн/км–ээр тооцно

Ашиг (Benefit). Зардлаа нөхсөний дараа үлдэх мөнгөн дүн буюу бараа бүтээгдэхүүний үнэ, өртгийн зөрүү

Ашигт малтмал (Mineral resources). Эрдэс байдлаар нь эсвэл баяжуулан боловсруулж үйлдвэрлэл, аж ахуйд ашиглаж болох эрдсийн нэгдэл

Аялал жуулчлал (Tourism). Хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа 1–183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор өөр газар нутагт аялах үйл ажиллагаа

Байгалийн нөөц (Natural resources). Үйлдвэрлэл аж ахуйд ашиглаж болох байгалийн баялаг

Байгалийн нөөцийн хангамж (Resource sufficiency). Нөөцийн хэмжээ ба ашиглалтын харьцаагаар илэрхийлсэн үзүүлэлт

Байршил тодорхойлох хиймэл дагуулын систем (Global Navigation Satellite System). Хиймэл дагуулуудын дохионы тусламжтайгаар гео–орон зайн байршлыг тодорхойлдог навигацийн системийн ерөнхий нэр

Банк (Bank). Зээл, төлбөрийн зуучлал, хадгаламж хуримтлуулах, мөнгөн дэвсгэрт чек гэх мэт зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага

Бартер (Barter). Мөнгөний оролцоогүйгээр нэг таваарыг нөгөөгөөр солих үйл ажиллагаа

Бизнесийн төв дүүрэг (Central business district). Газар

Geography Department, Mongolian National University of Education

Introduction to Human Geography

Edited by Batchuluun Yembuu, Tsogbadral Khurelbaatar

Chapters

1. **Brief Introduction to Human Geography** (Tsogbadral Khurelbaatar, Enkhjargal Purevsuren & Bat-Erdene Tsedev)
2. **Development Geography** (Batchuluun Yembuu)
3. **Population Geography** (Batchuluun Yembuu) & Uranchimeg Getsel)
4. **Cultural Geography** (Batchuluun Yembuu & Tsogbadral Khurelbaatar)
5. **Urban Geography** (Bat-Erdene Tsedev)
6. **Geography of Natural Resources** (Khadbaatar Sandag)
7. **Geography of Industry Sectors** (Batchuluun Yembuu & Uranchimeg Getsel)
8. **Geography of Primary Industries** (Khadbaatar Sandag)
9. **Geography of Secondary Industries** (Tsogbadral Khurelbaatar)
10. **Geography of Tertiary and Quaternary Industries** (Ser-Od Tsedevdorj)
11. **Human-Environment interactions and sustainability** (Batchuluun Yembuu & Khadbaatar Sandag)

